



Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятад Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль /2015/

Тайлангийн төрөл: Бодлого хөтөлбөрийн мэдээлэл

Баталсан: Jennifer Clever

Бэлтгэсэн: FAS мэргэжилтнүүд

Тайлангийн тойм:

2015 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Хятад Улс уг хуулийг шинэ Хүнсний аюулгүй байдлын тухай хууль хэмээн зарлаж, 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэхүү тайлан нь уг хуулийн албан ёсны бус орчуулга болно.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль

/бүрэн эхээр/

2009 оны 2 дугаар сарын 28-ны өдөр 11 дэх удаагийн Бүх Улсын Ардын төлөөлөгчдийн 7 дугаар Их хурлаар Байнгын хорооноос тус хуулийг хэлэлцэн баталж, 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 12 дахь Бүх Улсын Ардын төлөөлөгчдийн Их хурлаар Байнгын Хорооноос нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

Гарчиг

Бүлэг 1: Нийтлэг үндэслэл

Бүлэг 2: Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналт, үнэлгээ

Бүлэг 3: Хүнсний аюулгүй байдлын стандартууд

Бүлэг 4: Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлт

Хэсэг 1. Ерөнхий журам

Хэсэг 2. Үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн үеийн үйл ажиллагааны хяналт

Хэсэг 3. Бүтээгдэхүүний савлагаа, шошго, зар сурталчилгаа

Хэсэг 4. Тусгай хүнс

Бүлэг 5: Хүнсний хяналт, шалгалт

Бүлэг 6: Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импорт

Бүлэг 7: Хүнсний аюулгүй байдлын ослын зохицуулалт

Бүлэг 8: Хяналт шалгалт болон захиргааны үйл ажиллагаа

Бүлэг 9: Хууль зүйн хариуцлага

Бүлэг 10: Нэмэлт заалт

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.

Энэ хуулийн зорилт нь хүнсний аюулгүй байдлыг хамгаалах тухай болон нийт хүн амын эрүүл мэнд, аюулгүй амьдралыг хамгаалахад оршино.

2 дугаар зүйл.

Энэ хуулийг дараах үйл ажиллагаанд оролцогч бүх талууд дагаж мөрдөнө:

- i. Хүнсний үйлдвэрлэл болон боловсруулалт /цаашид Хүнсний үйлдвэрлэл гэх/, хүнсний борлуулалт болон рестораны үйлчилгээ /цаашид Хүнсний нийлүүлэлт гэх/
- ii. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон нийлүүлэлт
- iii. Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтэд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, хэрэгслийг ариутгах болон халдваргүйжүүлэх бодисууд, хадгалах сав, савлагааны материалууд /цаашид Хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд гэх/ - ын үйлдвэрлэл болон нийлүүлэлт
- iv. Хүнс үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийн хэрэглээ
- v. Хүнсний хадгалалт болон тээвэрлэлт, мөн
- vi. Хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийн аюулгүй байдлын удирдлага

Газар тариалангийн гаралтай хүнсэнд хэрэглэж болохуйц анхдагч бүтээгдэхүүнүүдийн / цаашид Хүнсэнд хэрэглэж болохуйц бүтээгдэхүүнүүд гэх/ аюулгүй байдлын болон чанарын зохицуулалтын удирдлага нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн чанар аюулгүй байдлын тухай хуулийн заалтуудаар зохицуулагдана. Харин энэ хуульд хамаарах зах зээлийн борлуулалт, холбогдох чанарын болон аюулгүй байдлын стандартууд боловсруулах, хүнсэнд хэрэглэж болохуйц шинэ бүтээгдэхүүнүүдийн аюулгүй байдлын мэдээлэл түгээх болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зардал зэргүүд нь энэхүү хуулийн заалтуудаар зохицуулагдана.

3 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдал нь урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны бүрэн хяналт, эрсдлийн удирдлага болон нийтийн эрх ашигт нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, хатуу чанд хяналт, удирдлагын цогц тогтолцоог бий болгох үйл ажиллагаа юм.

4 дүгээр зүйл.

Хүнс үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчид нь өөрсдийн үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

Хүнс үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид нь хүнсний аюулгүй байдлын стандарт болон холбогдох хууль дүрмийг дагаж мөрдөн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлнэ. Нийгэм, хүн амд өөрсдийн хүнсний аюулгүй байдлын баталгаа гаргаж, найдвартай, хувийн дэг журамтай, хариуцлагатай байвал зохино. Тэд нийгмийн хяналтан дор байх ба нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх ёстой

5 дугаар зүйл.

Төрийн зөвлөл нь Хүнсний аюулгүй байдлын хороог байгуулж, үйл ажиллагаа, үүргийг хянаж тогтооно.

Төрийн зөвлөлөөс тогтоосны дагуу Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь уг хуульд заасан үүргийн хүрээнд хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавина.

Төрийн зөвлөлийн харьяа эрүүл мэндийн яамд, комиссууд, газрууд нь уг хуульд заасан чиг үүргийн хүрээнд Төрийн зөвлөлөөс тогтоосны дагуу хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналт, үнэлгээг зохион байгуулах ба Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагатай хамтран үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг боловсруулж гаргана.

Төрийн зөвлөлийн харьяа бусад газрууд нь хүнсний аюулгүй байдлыг хангахад уг хуульд заасан чиг үүргийн хүрээнд Төрийн зөвлөлөөс тогтоосны дагуу ажиллана.

6 дугаар зүйл.

Мужийн түвшнээс дээш шатны Орон нутгийн захиргааны байгууллага нь эрх мэдлийнхээ хүрээнд хүнсний аюулгүй байдлын хяналт болон захиргааны үйл ажиллагааг хариуцаж, төвлөрсөн хэлбэрээр хүнсний аюулгүй байдлын хяналт болон захиргааны үйл ажиллагааг удирдан, зохион байгуулж, зохицуулах бөгөөд хүнсний аюулгүй байдалтай холбогдон гарсан зөрчлийг шийдвэрлэхээс гадна хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагааны ажиллах механизм, мэдээллийг түгээх механизмыг бүх шатанд бий болгон сайжруулна.

Төрийн зөвлөлөөс тогтоосны дагуу Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох бусад газруудын үүргийг, уг хуулийн заалтуудыг үндэслэн Мужийн түвшнээс дээш шатны Орон нутгийн захиргааны байгууллага нь тодорхойлно. Холбогдох газрууд нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу оролцоно.

Мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь онцгой бүс нутгуудад эсвэл жижиг хотуудад албан газруудыг байршуулна.

7 дугаар зүйл.

Мужийн түвшнээс дээд шатны Орон нутгийн захиргааны байгууллага нь хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагааны үүрэг хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ. Дээд шатны захиргааны байгууллага нь, харьяалагдах доод шатны захиргааны байгууллагын хэрэгжүүлсэн хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагааг хянан шалгаж, үнэлж дүгнэнэ. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, ижил түвшний бусад газруудаас хэрэгжүүлсэн хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагааг Мужийн түвшнээс дээш шатны Орон нутгийн захиргааны байгууллага хянаж үнэлнэ.

8 дугаар зүйл.

Мужийн түвшнээс дээш шатны Орон нутгийн захиргааны байгууллага нь үндэсний эдийн засаг нийгмийн хөгжлийн төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдлыг оруулж, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор засгийн газрын төсөвт хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардлыг тусгаж, түүний хяналтын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Мужийн түвшний захиргааны байгууллагын харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон бусад газрууд нь уг хуульд нийцүүлэн өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлж, хоорондын харилцаа холбоог дэмжиж, хамтран ажиллавал зохино.

9 дүгээр зүйл.

Хүнсний аж үйлдвэрийн холбооноос аж үйлдвэрийн дэг журмыг бэхжүүлж, аж үйлдвэрийн стандартыг боловсруулан сайжруулж, шагнал урамшууллын болон шийтгэлийн механизмыг холбооны дүрэм журамд нийцүүлэх, хүнсний аюулгүй байдал, технологийн тухай мэдээлэл олгох үйлчилгээг явуулна. Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн үйл ажиллагааг хуулийн дагуу удирдан чиглүүлж, аж үйлдвэрийн нэгдмэл байдлыг хангаж, хүнсний аюулгүй байдлын тухай мэдлэгийг сурталчлан дэлгэрүүлнэ.

Хэрэглэгчдийн холбоо болон бусад байгууллагууд нь уг хуулийг зөрчсөн үйлдэл, хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашигт хохирол учруулсан үйлдэлд нийгмийн хяналт тавьж ажиллана.

10 дугаар зүйл.

Бүх шатны захиргааны байгууллагууд нь хүнсний аюулгүй байдлын мэдлэг мэдээллийг сайжруулах, сурталчлан дэлгэрүүлэх үйл ажиллагааг явуулна. Олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, автономит үйл ажиллагаатай анхан шатны байгууллагуудад болон хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд хүнсний аюулгүй байдлын стандарттай холбоотой хууль дүрмүүдийг таниулан мэдүүлнэ. Эрүүл зохистой хооллох арга дэглэмийг санаачилж, хэрэглэгчдэд хүнсний аюулгүй байдал болон өөрийгөө хамгаалах мэдлэг ойлголтыг олгоно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хүнсний аюулгүй байдлыг зөрчсөн үйлдэлд олон нийтийн хяналт тавьж, олон нийтийн эрх ашгийн төлөө хүнсний аюулгүй байдлын стандартууд, ойлголтууд болон хууль журмыг таниулах аян зохион байгуулна. Хүнсний аюулгүй байдлын тухай хэвлэл нийтлэл болон тайлангууд нь баталгаатай, шударга байх ёстой.

11 дүгээр зүйл.

Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хүнс үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдийн гаргасан хүнсний аюулгүй байдлын тухай судалгааны ажил, сүүлийн үеийн шинэлэг санааны технологиг болон удирдлагын дүрмүүдийг нэвтрүүлэхэд төрөөс дэмжиж туслалцаа үзүүлнэ.

Төрөөс пестицидийн хэрэглээний тухай хатуу чанга захиргааны дүрмийг хэрэгжүүлж, онцгой эсвэл их хэмжээний хортой, ихээр үлдэгдэл гаргадаг пестицидийг арилгаж устгах арга хэмжээ авч, орлуулагч бүтээгдэхүүний судалгааны ажлуудыг дэмжин, үр дүн өндөртэй, бага хэмжээний хортой, үлдэгдэл бага ялгаруулдаг пестицидийн хэрэглээг дэмжинэ.

12 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын тухай хяналт, захиргааны үйл ажиллагааны талаар дурын байгууллага, хувь хүн санал дэвшүүлж, холбогдох газруудаас хүнсний аюулгүй байдлын тухай мэдээлэл авч, хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлж болно.

13 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдалд ихээхэн хувь нэмэр оруулсан хуулийн этгээд мөн/эсвэл хувь хүнийг холбогдох хууль, дүрмийн дагуу Төрөөс шагнаж урамшуулна.

Бүлэг 2. Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналт, үнэлгээ

14 дүгээр зүйл.

Төрөөс хүнсний аюулгүй байдлын эрсдлийг хянах тогтолцоог тогтоож, хүнсний гаралтай өвчнүүд, хүнсний бохирдол болон хүнсний хортой хүчин зүйлүүдэд хяналт тавина.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Чанарын хяналтын захиргааны байгууллага хамтран үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах эрсдлийн хяналтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон бусад холбогдох газрууд нь хүнсний аюулгүй байдлын тухай эрсдэлтэй мэдээллийг хүлээн авсны дараа, цаг алдалгүй шалган баталгаажуулж Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ. Эрүүл мэндийн байгууллага нь Төрийн зөвлөлийн харьяа бусад газруудтай хамтран Анагаах ухааны хүрээлэнгүүдээс мэдээлсэн хүнсний гаралтай өвчнүүдийн болон бусад хүнсний аюулгүй байдлын эрсдэлтэй хамааралтай мэдээллийг шинжилж, судлан тэр даруй үндэсний хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Засгийн газрын Эрүүл мэндийн байгууллагууд нь орон нутаг, автономит бүсүүд, өөрийн удирдлагатай хотууд зэрэг Төв засгийн газрын харьяа бүхий л шатанд Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Чанарын хяналтын захиргааны байгууллагуудтай хамтран эрх мэдлийнхээ хүрээнд үндэсний хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын төлөвлөгөөний дагуу харьяа бүс нутгийнхаа хүнсний аюулгүй байдлын хяналтын төлөвлөгөөг өөрийн онцлогт тохируулан боловсруулж, шинэчлэн найруулж Төрийн зөвлөлийн харьяа эрүүл мэндийн байгууллагад бүртгэлд оруулах, хэрэгжилтийг хангах зорилгоор өргөн мэдүүлнэ.

15 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын төлөвлөгөөний хүрээнд Техникийн мэргэжлийн хүрээлэнгүүд хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын төлөвлөөнд хяналт тавих ба мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, эрсдлийн үнэлгээний дүн шинжилгээ, үр дүнг тайлагнана.

Хариуцсан албаны хүмүүс хүнсний зориулалттай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн тариалалт болон боловсруулалтын байр, хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн үед дээж авах болон холбогдох мэдээллийг цуглуулж авч болно. Цуглуулсан дээжний үнийг зах зээлийн үнээр төлнө.

16 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын хүрээнд болзошгүй эрсдэл илэрвэл, мужийн түвшнээс дээгүүр харьяа эрүүл мэндийн байгууллагууд, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүнүүдийн захиргааны байгууллага болон бусад холбогдох газруудтай хамтран ахин хянаж үзээд, дээд шатны захиргааны байгууллагын харьяа Эрүүл мэндийн байгууллагад тайлагнана. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүнүүдийн захиргааны байгууллага болон бусад холбогдох газрууд дараагийн шатны шинжилгээний ажлыг санаачлан зохион байгуулна. 17 дугаар зүйл.

Төрөөс хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний тогтолцоог бий болгоно. Эрсдлийн үнэлгээг хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд дэх хорт бодисуудыг биологийн, химийн болон физикийн хүрээнд шинжлэх замаар явуулж, хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын мэдээлэл, шинжлэх ухааны мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг харгалзан үзэж тодорхойлно.

Төрийн зөвлөлийн харьяа эрүүл мэндийн байгууллага нь хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хариуцан ажиллах бөгөөд Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ тогтоох мэргэжлийн хороо байгуулна. Тус хороонд анагаах ухааны, хөдөө аж ахуйн, хүнсний, шим тэжээлийн, биологийн болон хүрээлэн буй орчны шинжээчдийг ажиллуулан хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг гаргуулна. Эрүүл мэндийн байгууллага нь үнэлгээний хорооноос гарсан эрсдлийн үнэлгээг нийтэд ил тод байлгана.

Пестицид, бордоо, мал эмнэлгийн эм, малын тэжээл болон малын тэжээлийн нэмэлтүүдийн аюулгүй байдлын үнэлгээг хүнсний аюулгүй байдлын мэргэжлийн хорооны шинжээчдийг байлцуулан гаргана.

Эрсдлийн үнэлгээ хийлгэхэд хүнс үйлдвэрлэгч болон нийлүүлэгчдэд ямар нэг хураамж ногдуулахгүй. Цуглуулсан дээжний үнийг зах зээлийн үнээр төлнө.

18 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг дор дурдсан нөхцөлд хийнэ:

- i. Хүнсний аюулгүй байдлын хяналтын явцад илэрсэн эсвэл бусад этгээдүүдийн мэдээлсний дагуу хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдэд учирч болзошгүй эрсдэл байх.
- ii. Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын боловсруулалт, нэмэлт өөрчлөлт оруулахад эрсдлийн үнэлгээ шаардлагатай болох.
- iii. Хяналт тавьж, удирдах шаардлага бүхий гол салбарууд болон төрлүүдийг тодорхойлоход эрсдлийн үнэлгээ шаардлагатай болох.
- iv. Хүнсний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц хүчин зүйлүүд шинээр тогтоогдсон тохиолдолд,

- v. Тодорхой хүчин зүйлс нь хүнсний аюулгүй байдалд аюул учруулах эсэхийг тодорхойлоход эрсдлийн үнэлгээ шаардлагатай болох,
- vi. Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай гэж үзвэл эрсдлийн үнэлгээг хийнэ.

19 дүгээр зүйл.

Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, чанарын хяналтын байгууллага, хөдөө аж ахуйн байгууллага болон Төрийн зөвлөлийн харьяа бусад газруудаас хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийгдэх шаардлагатай гэж үзвэл, эрүүл мэндийн байгууллагад эрсдлийн эх үүсвэр гэж үзсэн материал, холбогдох магадлагааны талаар мэдээлэл дүгнэлтийг өгнө. 18 дугаар зүйлд дурьдсан нөхцөл байдлуудаас илэрвэл Төрийн зөвлөлийн харьяа эрүүл мэндийн байгууллага тэр даруй эрсдлийн үнэлгээг явуулж, үнэлгээний үр дүнг холбогдох газруудад мэдээлнэ.

20 дугаар зүйл.

Орон нутгийн түвшнээс дээш шатны эрүүл мэндийн байгууллага, хөдөө аж ахуйн байгууллагууд нь хүнс болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн аюулгүй байдлын эрсдлийн хяналтын мэдээллийг цаг тухайд нь солилцоно.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, хөдөө аж ахуйн байгууллагууд нь хүнс болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнүүдийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болохуйц эрсдлийн үнэлгээний үр дүнг цаг тухайд нь солилцоно.

21 дүгээр зүйл.

Хүнсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болохуйц эрсдлийн үнэлгээний үр дүн нь хүнсний аюулгүй байдлын хяналт, захиргааны үйл ажиллагааны хэрэгжилтийн болон хүнсний аюулгүй байдлын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, боловсруулахад ашиглагдах шинжлэх ухааны баримт болно.

Хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон Хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд нь хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний үр дүнгээр аюултай гэж гарсан тохиолдолд, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Чанарын хяналтын байгууллага болон бусад Төрийн зөвлөлийн харьяа холбогдох газрууд нь холбогдох чиг үүргийн хүрээнд тухайн мэдээллүүдийг нийтэд ил болгох, хэрэглэгчдэд тухайн хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг хаях буюу хэрэглэхээ зогсоох талаар мэдээлэх, түүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг түдгэлзүүлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг авна. Уг тохиолдлын хүрээнд үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах бол Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн

байгууллага, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагатай хамтран үндэсний стандартыг боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулна.

22 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болохуйц эрсдлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, бусад холбогдох газруудтай хамтран хүнсний аюулгүй байдлын тухай иж бүрэн судалгаа, шинжилгээг хийнэ. Уг иж бүрэн судалгаа шинжилгээний үр дүнд тухайн хүнс өндөр эрсдэлтэйд тооцогдвол Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагагаас хүнсний аюулгүй байдлын эрсдлийн анхааруулга гаргаж, уг мэдээллийг нийтэд ил болгоно.

23 дугаар зүйл.

Мужийн түвшнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон бусад холбогдох газрууд, хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний мэргэжлийн комисс болон үүний мэргэжлийн хүрээлэнгээс шинжлэх ухаанч, зорилго цаг үеэ олсон, нээлттэй зарчимтайгаар хүнс үйлдвэрлэгч болон нийлүүлэгчдийг Хүнсний хяналтын хүрээлэн, гэрчилгээний хүрээлэн, Хүнсний аж үйдвэрийн холбоо, Хэрэглэгчдийн холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамт зохион байгуулалттайгаар хүнсний аюулгүй байдлын хяналт болон захиргааны үйл ажиллагаа, болон эрсдлийн үнэлгээний талаар мэдээлэл солилцуулна.

Бүлэг 3.Хүнсний аюулгүй байдлын стандартууд

24 дүгээр зүйл.

Хүнсний аюулгүй байдлын стандарт боловсруулах нь шинжлэх ухаанч, үндэслэлтэй, аюулгүй байдлыг хангасан, найдвартай мөн нийгмийн эрүүл мэндийг хангахад чиглэсэн байх ёстой.

25 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын стандарт нь заавал дагаж мөрдөх стандарт юм. Хүнсний аюулгүй байдлын стандартаас гадна, заавал дагаж мөрдөх хүнсний бусад стандарт боловсруулж болохгүй.

26 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын стандарт нь дараах агуулгыг хамарна:

- i. Хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнд агуулагдсан хүний эрүүл мэндэд хортой шимэгч организм, пестицидийн үлдэгдэл, мал эмнэлгийн эмийн үлдэгдэл, биотоксин ба хүнд металлууд болон бусад материалын хязгаарлалт,
- ii. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүдийн төрөл, хэрэглээ болон зохистой хэмжээ,
- iii. Нярай хүүхэд болон нийгмийн эмзэг бүлгийн хүн амд зориулсан анхдагч болон хоёрдогч хүнсний шим тэжээлийн найрлагын шаардлага,
- iv. Эмчилгээний болон шим тэжээлт хоол хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн шошго, тэмдэглэгээ, зориулалт,
- v. Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтэд тавигдах хүнсний эрүүл ахуйн шаардлагууд,
- vi. Хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн чанарын шаардлагууд,
- vii. Хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн хүнсний хяналтын арга зүй болон үзүүлэлтүүд
- viii. Хүнсний аюулгүй байдлын стандартад кодлох шаардлагатай бусад зүйлс

27 дугаар зүйл.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагатай хамтран үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг боловсруулж гаргана. Төрийн зөвлөлийн харьяа Стандартчилалын байгууллага нь тухайн боловсруулж гаргасан хүнсний аюулгүй байдлын стандартын агуулгын хүрээнд үндэсний стандартын талаархи мэдээллээр хангана.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, Хөдөө аж ахуйн байгууллага болон Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагатай хамтран пестицидүүд болон мал эмнэлгийн эмийн үлдэгдлийн

хязгаарлалт, тэдгээрийн хяналтын арга зүй, үзүүлэлтүүдэд тавигдах хязгаарлалтын заалтуудыг боловсруулж гаргана.

Төрийн зөвлөлийн харьяа Хөдөө аж ахуйн байгууллага, Эрүүл мэндийн байгууллагатай хамтран мал, шувууны нядалгаатай холбоотой хяналтын үзлэгийг зохион байгуулна.

28 дугаар зүйл.

Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын боловсруулахдаа Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний үр дүнг бүрэн харгалзан үзэж, холбогдох олон улсын стандартууд болон олон улсын хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээнээс иш татан үндэсний хүнсний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээний үр дүнд үндэслэсэн байна. Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын төслийг олон нийтэд ил байршуулж, хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчид болон холбогдох газруудын санал бодлыг өргөнөөр хүлээн авна.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас томилсон Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын хяналтын хороогоор Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартын хэрэгжилтийг хянаж батална. Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын хяналтын хороо нь анагаах ухааны шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, хоол хүнс, шим тэжээлт бодис, биологи болон хүрээлэн буй орчны мэргэжилтнүүдээс бүрдэх ба холбогдох Төрийн зөвлөлийн харьяа газруудын төлөөлөгчид, Хүнсний аж үйлдвэрийн холбоо, хэрэглэгчдийн холбооны төлөөлөгчид мөн хамаарах бөгөөд үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын төслийн өвөрмөц чанар болон практикт ашиглагдах боломжийг үнэлнэ.

29 дүгээр зүйл.

Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартад орон нутгийн хоол хүнсэнд зориулсан хэсэг байхгүй бол Төв засгийн газрын шууд харьяа орон нутгийн, автономит бүсүүд болон өөрийн удирдлагатай хотуудын Эрүүл мэндийн байгууллагаас хүнсний аюулгүй байдлын талаар орон нутгийн хүнсний стандартыг боловсруулан гаргаж, Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагад илгээж, бүртгүүлж болно. Тухайн стандарттай хамааралтай үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт шинээр гарснаар орон нутгийн стандартуудыг хүчингүй болгоно.

30 дугаар зүйл.

Төрөөс хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгжүүдийг үндэсний эсхүл орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандартаас илүү хатуу нөхцөлтэй аж ахуй

нэгжийн дотоод стандартыг боловсруулан гаргаж,Төв засгийн газрын шууд харьяа орон нутгийн, автономит бүсүүд болон өөрийн удирдлагатай хотуудын Эрүүл мэндийн байгууллагад илгээж бүртгүүлэхийг дэмжинэ.

31 дүгээр зүйл.

Орон нутгийн түвшний Эрүүл мэндийн байгууллагууд болон түүнээс дээш шатны байгууллагаас боловсруулан гаргасан үндэсний, орон нутгийн, мөн аж ахуйн нэгжүүдийн хүнсний аюулгүй байдлын стандартыг өөрийн вебсайтад олон нийтэд татаж авах болон хянаж үзэх боломжтойгоор байршуулна.

Хүнсний аюулгүй байдлын стандартын хэрэгжилттэй холбоотой үүссэн аливаа асуудалд Орон нутгийн түвшний болон түүнээс дээш шатны Эрүүл мэндийн байгууллагууд холбогдох газруудтай хамтран хариулт өгнө.

32 дугаар зүйл.

Орон нутгийн түвшний болон түүнээс дээш шатны Эрүүл мэндийн байгууллагууд өөртэй ижил шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Хөдөө аж ахуйн байгууллагуудтай хамтран үндэсний болон орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг үнэлж дүгнэж, үнэлгээний үр дүнгийн дагуу хүнсний аюулгүй байдлын стандартуудад нэмэлт өөрчлөлт оруулна.

Орон нутгийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Чанарын хяналтын байгууллага болон Хөдөө аж ахуйн байгууллагууд нь хүнсний аюулгүй байдлын стандартын хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлуудыг цуглуулж, нэгтгэн дүгнээд тэдгээр асуудлуудыг ижил түвшний Эрүүл мэндийн байгууллагуудтай зөвшилцөнө.

Хүнсний аюулгүй байдлын стандартын хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлыг хүнс үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид мөн/эсвэл Хүнсний аж үйлдвэрийн холбооноос тэр даруй Эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

Бүлэг 4. Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлт

Хэсэг 1: Ерөнхий журам

33 дугаар зүйл.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчид холбогдох хүнсний аюулгүй байдлын стандартыг болон дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө:

- i. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь үйлдвэрлэсэн болон нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ төрөл, тоо хэмжээнд тохирсон түүхий эд боловсруулалт явуулах, савлагаа хийх болон хадгалах байртай байна. Уг байрыг цэвэр цэмцгэр байлгаж, хорт болон аюултай материал, бохирдлын эх үүсвэрийг хадгалах байрнаас тодорхой зайтай байршуулна;
- ii. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь, үйлдвэрлэсэн болон нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ төрөл, тоо хэмжээнд тохирсон ариутгалын хэсэг, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, өдрийн гэрэлтүүлэг, гэрэлтүүлэг, агааржуулалт, зэврэлт болон тоосжилт, ялаа, өт хорхой, хархнаас сэргийлсэн, угаалгын өрөө болон бохир ус гадагшлуулах, хог хаягдлыг хадгалах, зайлуулах зэргийг агуулсан тоног төхөөрөмж, байгууламжтай байна;
- iii. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь үндсэн болон цагийн хүнсний аюулгүй байдлын техникч, хүнсний аюулгүй байдлын менежерүүдтэй байх ба хүнсний аюулгүй байдлыг хангах дүрэм журам, тогтолцоотой байна;
- iv. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь тоног төхөөрөмжөө байршуулахдаа шууд хэрэглэж болохуйц хүнсийг түүхий эд, бэлэн болсон бүтээгдэхүүнүүд болон хортой эсхүл бохир зүйлүүдээс дамжин бохирдохоос урьдчилан сэргийлэх байдлаар байршуулна
- v. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь ширээний хэрэгсэл, гал тогооны хэрэгсэл, шууд хэрэглээний хүнс агуулах савыг ашиглахын өмнө угааж ариутгана, гал тогооны хэрэгсэл болон сав суулгыг ашигласны дараагаар мөн угааж цэвэрлэнэ
- vi. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь хүнсний хадгалалт, зөөвөрлөлт болон ачих/буулгахад аюулгүй сав суулга, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэрэглэх ба хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай температур, чийглэгийг барьж ажиллана. Хоол хүнсийг хортой, аюултай зүйлстэй хамт хадгалах зөөвөрлөхийг хатуу хориглоно,
- vii. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь шууд хэрэглээний зориулалттай хүнсний агуулах сав, ширээний хэрэгсэл болон савлагааг элдэв сөрөг нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байхаар сонгож хэрэглэнэ
- viii. Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн ажилтнууд хувийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж, гараа тогтмол угааж, цэвэр хувцас, малгай өмсөж, ариутгаж цэвэрлэсэн хүнс агуулах сав, худалдаалах хэрэгсэл,

баглаа боодолгүй шууд хэрэглээний хүнсний зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглана.

- ix. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь үндэсний эрүүл ахуйн стандартад нийцсэн ундны усыг ашиглана,
- x. Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь хүний биед сөрөг нөлөөгүй ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис ашиглана,
- xi. Хууль тогтоомжид заасан бусад шаардлагууд хамаарна.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчдээс бусад хүнсний хадгалалт, зөөвөрлөлт, ачих/буулгах үйл ажиллагаанд оролцож буй бүх хүн дээрх хэсгийн (VI) зүйлд заасныг дагаж мөрдөнө.

34 дүгээр зүйл.

Доор дурьдагдсан хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэх, нийлүүлэхийг хориглоно:

- i. Хүнсний бус түүхий эдээр хийсэн хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээс бусад, хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй байж болзошгүй химийн бодисууд болон бусад бодисуудыг нэмсэн, дахин боловсруулсан хүнсийг хүнсний түүхий эд болгож ашигласан,
- ii. Эмгэг төрүүлэгч бичил биетэн, пестицидийн үлдэгдэл, мал эмнэлгийн эмийн үлдэгдэл, биотоксин, хүнд металлууд, бохирдуулагч болон хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй байж болзошгүй бусад бодисуудыг агуулсан болон хүнсний аюулгүй байдлын стандартыг зөрчиж үйлдвэрлэсэн хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд,
- iii. Хугацаа дууссан түүхий эд, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хийсэн хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд,
- iv. Хэт их хүнсний нэмэлт бүтээгдэхүүний агууламж бүхий хоол хүнс,
- v. Нярайн болон эмзэг бүлгийн хүн амын үндсэн болон нэмэлт хүнсний шим тэжээлийн бодисын найрлага нь хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөөгүй,
- vi. Ялзарсан эсхүл муудсан, өөх тос агуулсан, хөгцөрсөн эсхүл шавьжинд идэгдсэн, бохирдолтой, гадны биет агуулсан, хольц нэмсэн, хэвийн бус мэдрэгдэж буй хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд,
- vii. Халдварт өвчин, хор эсхүл тодорхойгүй шалтгааны улмаас үхсэн шувуу, мал, амьтан, усны амьтдын мах махан бүтээгдэхүүн,
- viii. Хяналт шалгалт хийгдээгүй эсхүл хориглосон, эсхүл хяналтын шаардлага хангаж чадаагүй, хориотой мах махан бүтээгдэхүүн,
- ix. Зөөвөрлөлтийн үед эсхүл савлагааны материал, агуулах савнуудаас бохирдсон хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн,
- x. Хадгалах хугацаа хэтэрсэн эсхүл хуурмаг үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаатай хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн,
- xi. Шошгогүйгээр урьдчилан савласан хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн,

- xii. Халдварт өвчнөөс сэргийлэх гэх мэт онцгой зорилгоор Төрөөс албадан үйлдвэрлэл, борлуулалтыг хориглосон хүнс гэх мэт,
- xiii. Хүнсний аюулгүй байдлын стандарт болон хууль, дүрмүүдтэй нийцээгүй бусад хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд,

35 дугаар зүйл.

Төрөөс хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн лиценз олгох тогтолцоог батлан гаргана. Хүнсний үйлдвэрлэл, хүнсний нийлүүлэлт болон нийтийн хоолны үйлчилгээ эрхэлж буй бүхий л албан байгууллага, хувь хүн лиценз авна. Гэхдээ, хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулахад лиценз авах шаардлагагүй.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Захиргааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн, уг хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-4 дэх заалт дахь хүсэлт гаргагчийн бүрдүүлэх баримт бичгийг хянаж, шаардлагатай бол хүсэлт гаргагчийн үйлдвэрлэл эсвэл нийлүүлэлтийн байрыг хянаж үзнэ. Шаардлага хангасан хүсэлт гаргагчийн лицензийг олгох ба лиценз олгохгүй тохиолдолд шалтгааныг бичгээр мэдэгдэнэ.

36 дугаар зүйл.

Хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлтэд оролцож буй жижиг хүнсний цехүүд болон хүнсний худалдагч нар үйлдвэрлэж, нийлүүлж буй хүнсний ариун цэврийг хангасан, сөрөг нөлөөгүй, аюулгүй байдал болон хүнсний аюулгүй байдлын шаардлагуудыг хангаж, нийлүүлэлтийн суваг болон нөхцөлийг дэмжиж, хангаж ажиллана. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагууд нь эдгээр хувь хүмүүст хяналт тавьж, удирдана.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны захиргааны байгууллагууд нь жижиг хүнсний цехүүд болон хүнсний худалдагчдын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн орчин, үйлчилгээг сайжруулах, нэгдсэн төлөвлөлтөнд оруулах цогц удирдлагыг хэрэгжүүлнэ. Мужийн түвшний болон түүнээс дээш шатны захиргааны байгууллагуудаас тэдэнд үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн нөхцөл байдлаа сайжруулахад, тогтсон байршилд ажиллахыг нь жишээлбэл: томоохон зах, худалдааны төв, эсхүл тогтоосон хугацаагаар түр зуурын үйл ажиллагаа явуулахад нь тусламж дэмжлэг үзүүлнэ.

Жижиг хүнсний цехүүд болон хүнсний худалдагчдийн захиргааны тусгай арга хэмжээг Төв засгийн газрын шууд харьяа орон нутаг, автономит бүсүүд болон өөрийн удирдлагатай хотууд нь боловсруулна.

37 дугаар зүйл.

Шинэ түүхий эд болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнтэй хүнс, үйлдвэрлэхээр хүсэлт гаргаж буй албан байгууллага, хувь хүн нь бүтээгдэхүүний орц дахь түүхий эд, материалуудаа Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагад илгээн, үнэлгээ хийлгэнэ. Эрүүл мэндийн байгууллага нь аюулгүй байдлын үнэлгээний материалын хяналтыг хүсэлт хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор зохион байгуулна. Шаардлага хангасан хүсэлт гаргагчийн лицензийг олгох ба лиценз олгохгүй тохиолдолд шалтгааныг бичгээр мэдэгдэнэ

38 дугаар зүйл.

Хоол хүнс, эм аль алинд нь багтдаг Хятадын уламжлалт нэмэлт бодисоос бусад эм бэлдмэлийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтэд нэмж болохгүй. Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагатай хамтран дээрх нэмэлт бодисын каталогийг боловсруулж, нийтэлнэ.

39 дүгээр зүйл.

Төрөөс хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн лиценз олгох тогтолцоог батлан гаргана. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оролцож буй албан байгууллага, хувь хүн нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүний төрөл, үйлдвэрлэлд тохирсон зориулалтын ажлын байртай, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж эсхүл хэрэгсэлтэй, мэргэжлийн техникч болон удирдлагын тогтолцоотой байж уг хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл явцыг мөрдөж хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн лиценз авна. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь Хүнсний аюулгүй байдлын стандарт болон хууль, дүрмүүдэд нийцсэн байна.

40 дүгээр зүйл.

Зөвхөн эрсдлийн үнэлгээгээр техникийн найдвартай аюулгүй нь тогтоогдсон, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг л аливаа бүтээгдэхүүний орц найрлагад оруулж болно. Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг хүнсний аюулгүй байдлын үнэлгээний үр дүн болон техникийн шаардлагатай үндэслэлийг харгалзан үзээд, цаг тухайд нь шинэчилнэ.

Хүнс үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.

41 дүгээр зүйл.

Хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нь Хүнсний аюулгүй байдлын стандарт болон хууль, дүрмүүдтэй нийцсэн байна. Өндөр эрсдэлтэй хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд, жишээлбэл сав, баглаа боодлын материал зэрэг хоол хүнсэнд шууд хамааралтай бүтээгдэхүүнүүд нь лицензтэй байх шаардлагатай бөгөөд холбогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийн үндэсний лицензийн захиргааны үйл ажиллагааны дагуу явагдана. Чанарын хяналтын байгууллага нь Хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлд хяналт тавьж, удирдана.

42 дугаар зүйл.

Төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах нарийвчилсан тогтолцоог батлан гаргана.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь хүнсний аюулгүй байдлыг хангах нарийвчилсан тогтолцоог уг хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ. Төрөөс хүнсний үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийг мэдээллийн технологийг ашиглан үйлдвэрлэл нийлүүлэлтийн мэдээллийг цуглуулах, хадгалах болон хүнсний аюулгүй байдлыг хангах нарийвчилсан тогтолцоог хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, хөдөө аж ахуйн байгууллага болон холбогдох газруудтай хамтран хүнсний аюулгүй байдлыг хангах нарийвчилсан тогтолцоог нэгдсэн системээр шийдвэрлэх механизмыг батлана.

43 дугаар зүйл.

Бүх шатны захиргааны байгууллагуудаас хүнсний түгээлт, нийлүүлэлтийн сүлжээ болон масс үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авна.

Төрөөс хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлт явуулдаг аж ахуйн нэгжүүдийг, хүнсний аюулгүй байдлын хариуцлагын даатгалд хамрагдахад нь дэмжлэг үзүүлнэ.

Хэсэг 2. Үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн үеийн үйл ажиллагааны хяналт

44 дүгээр зүйл.

Хүнс үйлдвэрлэгч болон нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд нь хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, сайжруулах, ажилтнуудыг бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар сургах болон хүнсний хяналтыг бэхжүүлж, хуульд нийцсэн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн ажлыг явуулна.

Хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтнууд нь хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, аж ахуйн нэгжүүдийн хүнсний аюулгүй байдлыг бүрэн хариуцан ажиллана.

Хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлт эрхлэгч аж ахуйн нэгжүүд нь хүнсний аюулгүй байдлын менежерүүдтэй байх ба тэднийг үйл ажиллагааны хяналт, сургалтад хамрагдуулж, чадварыг бэхжүүлнэ. Хяналтын үр дүнгээр хүнсний аюулгүй байдлын удирдлагын чадамжгүй хэмээн тогтоогдсон бол цаашид хүнсний аюулгүй байдлын менежерээр ажиллах боломжгүй. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас аж ахуйн нэгжүүдийн хүнсний аюулгүй байдлын менежерүүдэд гэнэтийн хяналт, үнэлгээг явуулж, үр дүнг тэдэнд нээлттэйгээр гаргана. Ийм хяналт үнэлгээг явуулахад төлбөр хураамж төлөхгүй.

45 дугаар зүйл.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчид нь дадлагажигч нартаа зориулж эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ. Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас хүнсний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц халдварт өвчтэй нь тогтоогдсон аливаа хүн шууд хэрэглэх зориулалттай хүнс бэлтгэх ямар ч үйл ажиллагаанд оролцож болохгүй.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчид нь шууд хэрэглэх зориулалттай хүнсэнд хүрэх шаардлагатай ямар нэг үйл ажиллагаанд оролцож байгаа бол жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, эрүүл мэндийн гэрчилгээгээ авсны дараагаар ажиллаж болно.

46 дугаар зүйл.

Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хяналтын шаардлагыг боловсруулж хэрэгжүүлнэ:

- i. Түүхий эдийг худалдан авах, үзлэг хийх, хүлээн авах, түүхий эдэд хяналт тавих,
- ii. Үйлдвэрлэл, тоног төхөөрөмж, хадгалалт болон сав савлагаа гэх мэт гол үйл ажиллагаануудад хяналт тавих,
- iii. Түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бэлэн бүтээгдэхүүнд хяналт тавих,
- iv. Хүргэлт, тээвэрлэлтэд хяналт тавина.

47 дугаар зүйл.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь хүнсний аюулгүй байдлын талаархи өөрийн хяналтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг тогтмол хянаж, үнэлнэ.

Үйлдвэрлэлийн буюу нийлүүлэлтийн нөхцөл өөрчлөгдсөний улмаас хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй тохиолдолд хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь засч залруулах арга хэмжээг авна. Хүнсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдлийн үед хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь уг бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг зогсоож тэр даруй харьяа нутаг дэвсгэрийн Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдээлнэ.

48 дугаар зүйл.

Төрөөс хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчдийг хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог сайжруулахын тулд үйлдвэрлэлийн тасралтгүй байдал, чанарын удирдлагын систем GMP-г хэрэгжүүлэх, цаашлаад эрсдлийн дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын удирдлагын тогтолцоо HACCP-г хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

GMP болон HACCP-аар баталгаажсан хүнсний аж ахуйн нэгжүүдэд Баталгаажуулалтын байгууллагаас хуульд заасны дагуу дагалдах хяналт-шинжилгээг тогтсон хугацаанд хийх ба ийн хяналт шинжилгээнд хамрагдаагүй тохиолдолд Баталгаажуулалтын байгууллагаас хуульд заасны дагуу гэрчилгээг цуцлаж, уг цуцлалтын талаар мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдэгдэж, мэдээллийг нийтэд ил болгоно. Баталгаажуулалтын байгууллагаас дагалдах хяналт-шинжилгээнүүдийг хийхэд ямар нэг төлбөр хураамж төлөхгүй.

49 дүгээр зүйл.

Хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь хөдөө аж ахуйн пестицид, бордоо, мал эмнэлгийн эм, тэжээл болон тэжээлийн нэмэлтийг хүнсний аюулгүй байдлын стандарт, төрийн бусад зохицуулалтын дагуу хэрэглэж, хэрэглээний давтамж болон хэрэглээний бус хөдөө аж ахуйн орцуудын тухай зүйл заалтуудыг бүрэн дагаж мөрдөнө. Хүнсний ногоо, шийгуа, жимс, жимсгэнэ, цай болон Хятадын уламжлалт эмийн ургамал хэмээн Төрөөс тогтоосон ургамал зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд онцгой эсвэл ихээхэн хортой пестицид ашиглахыг хориглоно.

Хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, мэргэжлийн фермерүүдийн хоршоо нь хүнсэнд хэрэглэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүртгэл хийнэ.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны хөдөө аж ахуйн удирдлагын байгууллага нь хөдөө аж ахуйн орцуудын хэрэглээний зааварчилгаа, удирдамжаар хангаж, хөдөө аж ахуйн орцуудын аюулгүй хэрэглээний тогтолцоог бий болгож сайжруулна.

50 дугаар зүйл.

Хүнс үйлдвэрлэгч нь хүнсний түүхий эд, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг худалдан авахдаа ханган нийлүүлэгчийн лиценз, зөвшөөрлийг шалгах ёстой. Зөвшөөрлийн гэрчилгээгүй тохиолдолд хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу хүнсний түүхий эдийг шалгана. Хүнс үйлдвэрлэгчид нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй түүхий эд, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг худалдан авахгүй, хэрэглэхгүй.

Хүнс үйлдвэрлэгч нь орж ирж буй хүнсний түүхий эд, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүний нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, худалдан авсан огноо болон ханган нийлүүлэгчийн нэр, холбоо барих мэдээллийг баталгаажуулсан бүртгэл бий болгох ба холбогдох итгэмжлэлийн бичгийг хадгална. Хадгалах хугацаа дууссанаас хойш 6 сараас багагүй хугацаанд бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгална, хадгалах хугацаа нь тодорхойлогдоогүй тохиолдолд хадгалалтын хугацаа нь ямар ч тохиолдолд 2 жилээс бага байж болохгүй.

51 дүгээр зүйл.

Хүнс үйлдвэрлэгч нь гадагш гаргаж буй буй хүнсний хяналт шалгалтын гэрчилгээ, аюулгүй байдлын статусыг баталгаажуулсан байх ба гадагш гаргаж буй хүнсний хяналтын бүртгэлийг бий болгож, хөтлөнө. Уг бүртгэлд бүтээгдэхүүний нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, хяналтын гэрчилгээний дугаар, борлуулалтын огноо болон худалдан авагчийн нэр, хаяг, холбоо барих мэдээллийг агуулсан байх ба холбогдох итгэмжлэлүүдийг багтаана.

Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

52 дугаар зүйл.

Хүнсний түүхий эд, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь үйлдвэрлэж буй хүнсний түүхий эд, хүнсний

нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг хүнсний аюулгүй байдлын стандартад заасны дагуу хянана. Бүтээгдэхүүнийг хяналтад тэнцсэний дараа л үйлдвэрээс гаргах эсвэл худалдагдаж болно.

53 дугаар зүйл.

Хүнс нийлүүлэгчид нь хүнс худалдан авахдаа нийлүүлэгчийн гадагш гаргаж буй хүнсний лиценз, хяналтын гэрчилгээ болон бусад чанарын гэрчилгээнүүдийг /цаашид Чанарын гэрчилгээ гэх/ шалгах ёстой.

Хүнс нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд нь орж ирж буй хүнсний бүтээгдэхүүний нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, худалдан авсан огноо болон ханган нийлүүлэгчийн нэр болон холбоо барих мэдээллийг агуулсан хяналтын бүртгэлийг боловсруулж хөтлөх ба холбогдох итгэмжлэлүүдийг хадгална. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

Төвлөрсөн нийлүүлэлтийн загвартай хүнс нийлүүлэлтийн аж ахуйн нэгжүүдийн хувьд төв байран дээр нэгдсэн байдлаар нийлүүлэгчдийн хүнсний лиценз, зөвшөөрлийн гэрчилгээг шалгаж, орж ирж буй хүнсний хяналтын бүртгэлийг хөтөлж болно.

Бөөний худалдаа эрхэлдэг хүнс нийлүүлэгч аж ахуйн газрууд нь орж ирж буй хүнсний нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, бөөний хүнсний борлуулалтын огноо болон ханган нийлүүлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээллийг агуулсан хяналтын бүртгэлийг бий болгож хөтөлнө. Бүх холбогдох итгэмжлэлүүдийг хадгална. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

54 дүгээр зүйл.

Хүнс нийлүүлэгчид нь хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтын шаардлагын дагуу хүнсийг хадгалж, агуулахад байгаа хүнсийг тогтмол шалгаж, муудсан эсхүл хуучирсан хүнсийг тэр даруй гаргана.

Хүнс нийлүүлэгчид нь их хэмжээний хүнсийг хадгалах байгууламжид хадгалахдаа хүнсний нэр, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа болон үйлдвэрлэгчийн нэр, холбоо барих мэдээллийг заасан байх ёстой.

55 дугаар зүйл.

Нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь түүхий эдийн хяналтын шаардлагыг боловсруулж, хэрэгжүүлэх ба хүнсний аюулгүй байдлын стандартыг хангахгүй

байгаа түүхий эдийг худалдан авахаас татгалзана. Нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь боловсруулалтын ил тод байдал болон хүнсний түүхий эд, түүний эх үүсвэрүүдийн мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллана.

Нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь хүнс, түүхий эдийг боловсруулахаас өмнө тэдгээрийг шалгаж, уг хуулийн 34 дүгээр зүйлийн (VI)–д заасан аль нэг нөхцөл байдлыг хангахгүй байвал уг хүнс, түүхий эдийг боловсруулалтанд оруулж, хэрэглэхийг хориглоно.

56 дугаар зүйл.

Нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь хүнсний боловсруулалт, хадгалалт, бэлэн болсон хоол байрлуулах төхөөрөмж болон тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг доголдолгүй байлгаж, дулаан тусгаарлагч төхөөрөмжүүд болон хөлдөөгчөө цэвэр байлгаж, хянах шаардлагатай.

Нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь тогтоосон шаардлагын дагуу ширээний хэрэгслийг цэвэрлэж ариутгана, цэвэрлэж ариутгаагүй ширээний хэрэгслийг ашиглахыг хориглоно. Ширээний хэрэгслээ цэвэрлэж ариутгах ажиллагааг бусдаар хийлгэж буй нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь нэгдсэн журмаар ариутгал хийдэг мэргэшсэн ариутгах үйлчилгээний байгууллагаар хийлгүүлнэ.

57 дугаар зүйл.

Цэцэрлэг, сургууль, сувиллын газрууд болон барилгын талбайн цайны газрууд нь хүнсний аюулгүй байдлын стандарт болон хууль дүрмүүдийг бүрэн мөрдөнө, ямар ч албан байгууллага, хувь хүн хоолны үйлчилгээ үзүүлэгчдээс хоол захиалахдаа хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлт явуулах лицензтэй этгээдээс л авах ба шаардлагын дагуу захиалсан хоолыг шалгаж хянана. Хоолны үйлчилгээ үзүүлэгч нь хүнсний аюулгүй байдлын стандарт, хууль журмуудыг бүрэн мөрдөж, захиалгын дагуу хүнсний аюулгүй байдлыг хангасан хоол боловсруулна.

Цэцэрлэг, сургууль, сувиллын газрууд болон барилгын талбайн цайны газруудыг хариуцсан эрх бүхий байгууллагаас нэгдсэн журмаар хооллодог аж ахуйн нэгжүүдийн хүнсний аюулгүй байдлын эрсдлийг багасгах, мэдэгдээгүй хүнсний аюулгүй байдлын эрсдлийг арилгахаар хүнсний аюулгүй байдлын мэдлэг, өдөр тутмын зохицуулалтыг сайжруулж ажиллана.

58 дугаар зүйл.

Ширээний хэрэгсэл ариутгах үйлчилгээ үзүүлэгчид зохих үйл ажиллагаа явуулах байртай, цэвэрлэх, ариутгах тоног төхөөрөмж, хэрэгслүүдтэй байна.

Ус, ариутгагч бодис, угаагч бодис нь үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт, бусад үндэсний стандарт болон эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд нийцсэн байх ёстой.

Ширээний хэрэгсэл ариутгах үйлчилгээ үзүүлэгчид нь ариутгасан хэрэгслүүдийг хүргэж, багц багцаар нь хянаж, ариутгалын чанарын гэрчилгээ олгоно. Ариутгагдсан ширээний хэрэгслүүдийг тус тусад нь савлаж, нэр, хаяг, холбоо барих мэдээлэл болон ариутгасан огноо, ашиглах нөхцлийг зааж өгсөн байна.

59 дүгээр зүйл.

Хүнсний нэмэлт үйлдвэрлэгчид нь гадагш гаргаж буй хүнсний хяналт шалгалтын гэрчилгээ, аюулгүй байдлын статусыг баталгаажуулан гадагш гаргаж буй хүнсний нэмэлтийн хяналтын бүртгэлийг боловсруулж, хөтлөнө. Уг бүртгэлд хүнсний нэмэлтийн нэр, зориулалт, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, хяналтын гэрчилгээний дугаар, борлуулалтын огноо болон худалдан авагчийн нэр, хаяг, холбоо барих мэдээллийг агуулсан байх ба холбогдох итгэмжлэлүүдийг багтаана. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

60 дугаар зүйл.

Хүнсний нэмэлт нийлүүлэгчид нь хүнсний нэмэлт худалдан авахдаа ханган нийлүүлэгчийн лиценз, чанарын гэрчилгээг шалгах шаардлагатай. Үүнд хүнсний нэмэлтийн нэр, зориулалт, төрөл, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо эсвэл сериал дугаар, хадгалах хугацаа, хүнсний нэмэлтийг худалдан авсан огноо, ханган нийлүүлэгчийн нэр, холбоо барих мэдээлэл болон холбогдох итгэмжлэлүүдийг үнэн зөвөөр агуулсан байх ёстой. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

61 дүгээр зүйл.

Худалдааны нэгдсэн зах зээлийн операторууд, мухлаг түрээслэгчид болон худалдааны үзэсгэлэн зохион байгуулагчид нь хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний нийлүүлэгчдийн лицензийг хуулийн дагуу шалгаж, тэдний хүнсний аюулгүй байдлын менежментийн хариуцлагыг тодорхойлж, тэдний нийлүүлэлтийн орчин нөхцөл байдлыг тогтмол шалгах ёстой. Уг хуулийг зөрчсөн аливаа үйл ажиллагааг олж тогтоосон тохиолдолд, тэр даруй үйл ажиллагааг зогсоож мужийн түвшнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдээлнэ.

62 дугаар зүйл.

Онлайн хүнсний худалдааны гуравдагч этгээдийн платформын үйлчилгээ үзүүлэгчид нь зөвшөөрөгдсөн хүнс нийлүүлэгчдийн жинхэнэ нэрээр бүртгэлийг явуулж, тэдний хүнсний аюулгүй байдлын менежментийн хариуцлагыг болон хуулийн дагуу лицензийг олж авсан эсэхийг тодорхойлж, тэдний лицензийг шалгаж хянана. Уг хуулийг зөрчсөн аливаа үйл ажиллагааг олж тогтоосон тохиолдолд, тэр даруй үйл ажиллагааг зогсоож мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдээлнэ, ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тэд онлайн худалдааны платформ үйлчилгээг үзүүлэхээ зогсоож болно.

63 дугаар зүйл.

Төрөөс хүнсийг буцаан татах тогтолцоог тогтооно. Үйлдвэрлэгдэж буй хүнс нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй, хүний эрүүл мэндэд аюул учруулж болохуйц гэдгийг олж мэдсэн хүнс үйлдвэрлэгч нь тэр даруй хүнсний үйлвэрлэлийг зогсоож, зах зээлд нийлүүлэгдсэн хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татаж, холбогдох үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчдэд мэдэгдэж, буцаан таталтын бүртгэл мэдэгдлийг хийнэ.

Хүнс нийлүүлэгч нь үйлдвэрлэгдэж буй хүнс нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй, хүний эрүүл мэндэд аюул учруулж болохуйц гэдгийг олж мэдсэн тохиолдолд тэр даруй хоол үйлдвэрлэлийн ажиллагааг зогсоож, холбогдох үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчдэд мэдэгдэж, нийлүүлэлтийн түдгэлзүүлэлтийн бүртгэл, мэдэгдлийг хийнэ. Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнийг буцаан татах шаардлагатай гэж үзвэл тэр даруй буцаан таталт хийнэ. Өмнөх заалтад дурдсан нөхцөл байдал үүсэхэд болон хүнсний нийлүүлэгчийн зүйтэй гэж үзсэн тохиолдолд хүнсний нийлүүлэгч тухайн хүнсийг буцаан татна.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчид нь буцаан татагдсан хүнсийг ахин зах зээлд нийлүүлэхгүй байхаар ямар нэгэн хохирол учруулахааргүй арга хэмжээ авна. Хүнс үйлдвэрлэгчид нь шошго, тэмдэг эсвэл зориулалт нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцэхгүй байсан, буцаан татагдсан бүтээгдэхүүнийг засан сайжруулах арга хэмжээг авч, хүнсний аюулгүй байдлыг хангасны дараагаар үргэлжлүүлэн борлуулах боломжтой. Хүнс үйлдвэрлэгчид нь борлуулалт хийхдээ, засан сайжруулах арга хэмжээ авсан тухайгаа хэрэглэгчдэд мэдээлнэ.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь хүнсний бүтээгдэхүүний буцаан таталт болон устгалын талаар мэдээллийг мужийн түвшний эрх бүхий Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдэгдэнэ. Буцаан татагдсан хүнсийг аюулгүй устгалд оруулах тохиолдолд байршил, цагийг урьдчилан мэдээлнэ. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас өөрсдийн хүсэлтээр, газар дээр нь хяналтын ажиллагаа явуулж болно.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэ зүйлд заасны дагуу буцаан татах ажиллагаа хийгээгүй, үйлдвэрлэлийг зогсоож чадаагүй бол мужийн түвшний болон түүнээс дээш шатны эрх бүхий Чанарын хяналтын байгууллагаас уг хүнсийг худалдаалахыг зогсоох, буцаан таталт хийх тушаал гаргаж болно.

64 дүгээр зүйл.

Хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн бөөний худалдаа нь хяналт шалгалтын тоног төхөөрөмж, хяналтын байцаагчтай байх эсхүл энэ хуульд тодорхойлсон Хүнсний хяналт явуулдаг итгэмжлэгдсэн агентлагуудаар бөөний худалдааны бүтээгдэхүүний дээжийг авч хүнсний хяналт шалгалтад оруулна. Уг хүнсний бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцэхгүй байх тохиолдолд худалдааны төв нь нийлүүлэгчээс борлуулалтыг зогсоохыг шаардаж Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдээлнэ.

65 дугаар зүйл.

Хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэгчид нь орж ирж буй хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр, хэмжээ, худалдан авсан огноо, ханган нийлүүлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл болон холбогдох итгэмжлэлүүдийг хадгалж, хяналтын бүртгэлийг бий болгож хөтлөнө. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг 6 сараас багагүй хугацаанд хадгална.

66 дугаар зүйл.

Хүнсний нэмэлтүүдийн хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд буюу савлагааны материалууд нь зах зээлийн борлуулалтад гарсан хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг савлах, хадгалах, зөөвөрлөхөд хэрэглэгдэж буй муудахаас сэргийлэх бодис, хадгалах бодис нь үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн байх ёстой.

Хэсэг 3. Бүтээгдэхүүний савлагаа, шошго, зар сурталчилгаа

67 дугаар зүйл.

Урьдчилан савласан хүнсний савлагаан дээр дараах зүйлсийг заасан шошготой байна:

- i. Нэр, зориулалт, цэвэр агуулга, үйлдвэрлэсэн огноо,
- ii. Найрлагын бүрэлдэхүүнийг заасан хүснэгт,
- iii. Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл,
- iv. Хадгалах хугацаа,
- v. Бүтээгдэхүүний стандарт/-ууд/-ын код,
- vi. Хадгалах нөхцөл,

- vii. Үндэсний стандартын дагуу тогтоогдсон хүнсний нэмэлтүүдийн ерөнхий нэр,
- viii. Бүтээгдэхүүний лицензийн дугаар,
- ix. Бусад хэрэглэж болох хууль, журам, хүнсний аюулгүй байдлын стандартад тусгагдсан, зааж өгөх ёстой мэдээллүүд

Нярайн болон эмзэг бүлгийн хүн амын үндсэн болон нэмэлт хүнсний шим тэжээлийн бодисын найрлага болон агууламжийг зааж өгөх ёстой.

Хэрэв үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын тусгай заалт байгаа бол уг заалтыг дагаж мөрдөнө.

68 дугаар зүйл.

Хүнс нийлүүлэгчид нь хүнсний бүтээгдэхүүнийг их хэмжээгээр зарж байгаа тохиолдолд, агуулах сав буюу савлагааны гадна талд нь хүнсний нэр, үйлдвэрлэсэн огноо болон сериал дугаар, хадгалах хугацаа болон нийлүүлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээллийг зааж өгөх ёстой.

69 дүгээр зүйл.

Генетикийн өөрчлөлт оруулсан хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлт хийж буй тохиолдолд заалтын дагуу тэмдэглэсэн байх ёстой.

70 дугаар зүйл.

Хүнсний нэмэлтүүд нь шошго, заавар, савлагаатай байх ёстой. Уг хуулийн 69 дүгээр зүйлийн I-VI хэсэг VIII хэсэг болон IX хэсгүүдэд заасан мэдээллийг заавартаа агуулсан байх бөгөөд хүнсний нэмэлтүүдийн хэрэглээний хүрээ, тунгийн хэмжээ болон хэрэглээний аргуудыг мөн тусгаж Хүнсний нэмэлт гэж шошгон дээрээ заасан байх ёстой.

71 дүгээр зүйл.

Хүнс, хүнсний нэмэлтүүдийн шошго, зааварчилгаа болон савлагаан дээр худал буюу хэтрүүлсэн мэдээлэл агуулж болохгүй бөгөөд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчилгээний үүргүүдийг дурьдсан мэдэгдэл хийж болохгүй.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч нь шошго, зааварчилгаа болон савлагаан дээрх мэдэгдэлээс шалтгаалж хууль зүйн хариуцлага хүлээж болно.

Хүнс, хүнсний нэмэлтүүдийн шошго, зааварчилгаа нь тодорхой, харагдахуйц байх ба үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа нь уншихад хялбар байх ёстой.

Хүнс, хүнсний нэмэлтүүд нь шошго, зааварчилгаан дээрх мэдээллээс өөр байдаг бол худалдаалахыг хориглоно.

72 дугаар зүйл.

Хүнс нийлүүлэгчид нь хүнсний шошгон дээрх анхааруулах тэмдэг, тэмдэглэл болон сануулгыг харгалзан зах зээлд гаргана.

73 дугаар зүйл.

Хүнсний зар сурталчилгаа нь үнэн зөв мэдээллийг агуулсан, хуурамч мэдээлэл өгөөгүй болон халдварт өвчнөөс сэргийлэх эсвэл эмчилгээний үүргийг дурьдсан байж болохгүй. Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь зар сурталчилгааны үнэн зөв, хууль ёсны байдлыг хариуцна.

Мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон түүнээс дээш шатны байгууллага, хүнсний хяналт, шинжилгээг явуулдаг байгууллагууд буюу Хүнсний аж үйлдвэрийн холбоо зэргээс үйлчлүүлэгчдэд зар сурталчилгаагаар буюу бусад байдлаар ямар нэг хүнсний бүтээгдэхүүн санал болгож болохгүй. Хэрэглэгчдийн холбооноос ямар нэг төлбөр хураамжтай, ашгийн төлөө байдлаар хэрэглэгчдэд хүнсийг санал болгохыг хориглоно.

Хэсэг 4. Тусгай хүнс

74 дүгээр зүйл.

Төрийн зүгээс эмчилгээний хүнс, эмнэлгийн зориулалттай тусгай хүнс болон нярайн хүнсний тэжээл зэрэг тусгай хүнсний хяналт, удирдлагыг хатуу чанга хэрэгжүүлнэ.

75 дугаар зүйл.

Эмчилгээний хүнсний эмчилгээний гэх үүрэг нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх ба хүний биед хурц, хурцадмал, архаг өвчин үүсгэхгүй байх ёстой.

Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь Эрүүл мэндийн байгууллага болон Хятад эм бэлдмэлийн төрийн байгууллагатай хамтран эмчилгээний хоол хүнсний түүхий эдийн каталогийг боловсруулж гаргана.

Эмчилгээний хүнсний түүхий эдийн каталог нь түүхий эдийн нэр, тунгийн хэмжээ болон гаж нөлөөг тусгаж оруулсан байна. Уг каталог дахь түүхий эдийг зөвхөн эмчилгээний хүнсний үйлдвэрлэлд ашиглах ба бусад хүнсний үйлдвэрлэлд ашиглахгүй.

76 дугаар зүйл.

Түүхий эдийн каталогт ороогүй түүхий эдээр хийсэн эмчилгээний хүнс болон импортоор оруулж ирсэн эмчилгээний хүнсний бүртгэлийг Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад хандан хийлгэнэ. Импортоор оруулж ирсэн эмчилгээний хүнс нь шим тэжээлийн бодисын агууламжтай буюу нэмэлт витамин, эрдэс бодисуудтай байх тохиолдолд Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад өргөдөл гаргаж бүртгэл хийлгэнэ. Бусад эмчилгээний хүнсний тухай Төв засгийн газрын шууд харьяа орон нутгийн, автономит бүсүүдийн болон өөрийн удирдлагатай хотуудын Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагуудад өргөдөл гаргана.

Импортоор оруулж ирсэн эмчилгээний хүнс нь экспортлосон орны (бүсийн) эрх бүхий байгууллагын зах зээлд нийлүүлэх зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

77 дугаар зүйл.

Энэ хуульд заасны дагуу бүртгэл хийлгэхдээ судалгаа, хөгжлийн тайлан, эмчилгээний хүнсэн дэх бүтээгдэхүүний найрлага, үйлдвэрлэлийн процесс, аюулгүй байдлын болон эрүүл мэндийн үйл ажиллагааны үнэлгээ, шошго, заавар, шаардлагатай дээж бүтээгдэхүүнүүд болон шаардлагатай гэрчилгээ гэх мэт холбогдох баримтуудыг бүртгэлд бүртгүүлнэ. Хэрэв эмчилгээний хүнс нь аюулгүй байдлын шаардлагыг хангаж, хортой бодис агуулаагүй нь Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагын үнэлгээгээр тогтоогдвол бүртгэлийг хүчин төгөлдөр болгох ба хэрэв шаардлага хангаагүй бол бүртгэлд хамруулахгүй бөгөөд шалтгаанаа бичгээр мэдэгдэнэ. Түүхий эд, материалын каталогын жагсаалтанд ороогүй түүхий эдээр хийгдсэн эмчилгээний хүнсийг хүчинтэй гэж бүртгэлд бүртгэсэн бол уг түүхий эдийг эмчилгээний хүнсний түүхий эдийн каталогт нөхөж оруулна.

Эмчилгээний хүнс нь энэ хуульд зааснаар бүртгүүлэх шаардлагатай бол бүтээгдэхүүний найрлага, үйлдвэрлэлийн процесс, шошго, заавар болон бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны нөлөөлөх үүрэг зэрэг материалыг хавсаргана.

78 дугаар зүйл.

Эмчилгээний хүнсний шошго болон заавар нь өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчилгээний үүргийг агуулаагүй байх ба бүртгүүлсэн орц, найрлагын дагуу үнэн, бодитой байх төдийгүй уг бүтээгдэхүүнийг хэрэглэх тохиромжтой болон үл тохирох хүмүүсийг тодорхой тусгана. Үүнээс гадна үр нөлөөтэй эсвэл идэвхтэй найрлага агуулсан бүтээгдэхүүний гадна “Энэ бүтээгдэхүүн нь эмийг орлохгүй” гэсэн бичиг наана. Эмчилгээний хүнсний үйл ажиллагаа болоод найрлага нь шошго болон заавар дээрээ тусгагдсан байна.

79 дүгээр зүйл.

73-р зүйлийн нэгдүгээр хэсэгт зааснаас гадна эмчилгээний хүнсний сурталчилгаан дээр “Энэ бүтээгдэхүүн нь эмийг орлохгүй” гэсэн бичгийг тавина. Уг бичиг нь Төв засгийн газрын харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний орон нутгийн хяналтын байгууллагууд, автономит бүсүүд, өөрөө удирдлагатай хотууд болон тухайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн байгууллагууд оршиж буй газрын зөвшөөрлөөр олгогдсон байна. Төв засгийн газрын харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний орон нутгийн хяналтын байгууллагууд, автономит бүсүүд, өөрөө удирдлагатай хотууд нь эрүүл мэндийн бүтээгдэхүүний зар сурталчилгааны каталог, түүний агуулгыг боловсруулж, шинэчилнэ.

80 дугаар зүйл.

Эмнэлгийн тусгай зориулалтын хүнсийг Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад бүртгүүлнэ. Бүтээгдэхүүний найрлага, үйлдвэрлэлийн процесс, шошго, заавар гэх мэт хүнсний аюулгүй байдлыг нотлох материал, зохих хэмжээний тэжээллэг чанар, тусгай зориулалтын хүнсний эмнэлзүйн үр нөлөөг бүртгэлд бүртгүүлэхэд тусгана.

Эмнэлгийн тусгай зориулалтын хүнсний зар сурталчилгааг явуулахдаа БНХАУ-ын Зар сурталчилгааны тухай хууль болон эмийн сурталчилгаатай холбоотой бусад хууль, захиргааны журмуудад үндэслэн явуулна.

81 дүгээр зүйл.

Нярайн тэжээл үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд нь үйл ажилагааны процессын чанарын бүрэн хяналт буюу түүхий эд, материалаас эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл хяналт, үйлдвэрлэсэн нярайн тэжээлийг багц тус бүрээр хүнсний аюулгүй байдлыг хангахаар шинжилгээ хийнэ.

Хүнсний түүхий эд болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болох цэвэр сүү ба нэмэлт материалууд нь хууль, захиргааны журмуудад нийцсэн, үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг хангасан, нярайн өсөлтөнд хэрэгцээтэй тэжээллэг чанарын агууламжийг хангасан байна.

Нярайн тэжээл үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд нь хүнсний бүтээгдэхүүний түүхий эд, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний найрлага болон шошгыг Төв засгийн газрын харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний орон нутгийн хяналтын байгууллагууд, автономит бүсүүд, өөрөө удирдлагатай хотуудад хавсарган өгнө.

Нярайн хуурай сүүн тэжээлийн найрлагыг Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад бүртгүүлнэ.

Бүтээгдэхүүний найрлагын судалгаа, хөгжлийн тайлан болон бусад шинжлэх ухааны ба аюулгүй байдлыг нотлох баримтуудын хамт хавсаргана.

Дэд зөвлөлийн тогтоосноор нярайн хуурай сүүн тэжээлийг нэг аж ахуйн нэгж адил жор, найрлагаар өөр нэр өгч үйлдвэрлэхийг хориглоно.

82 дугаар зүйл.

Эмчилгээний хүнс, эмчилгээний тусгай зориулалттай хүнс болон нярайн хуурай сүүн тэжээлийн талаар бүртгүүлэгч болон бүртгэгч нар нь хавсаргасан материалын үнэн зөв эсэхэд хариуцлага хүлээнэ.

Харьяа болон дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь бүртгэгдсэн эмчилгээний хүнс, эмчилгээний тусгай зориулалттай хүнс болон нярайн хуурай сүүн тэжээлийн каталог гаргаж бүртгүүлэх явцад олж мэдсэн бизнесийн нууцтай холбоотой нууцлалыг чандлан хадгална.

Эмчилгээний хүнс, эмчилгээний тусгай зориулалттай хүнс болон нярайн хуурай сүүн тэжээл үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа бүртгэлд бүртгүүлсэн техникийн шаардлага, бүтээгдэхүүний найрлага болон үйлдвэрлэлийн процесст нийцүүлэн үйлдвэрлэлийг явуулна.

83 дугаар зүйл

Нийгмийн тодорхой бүлэгт зориулсан эмчилгээний хүнс, эмчилгээний тусгай зориулалттай хүнс болон нярайн хуурай сүүн тэжээл болон бусад үндсэн болон нэмэлт хүнс үйлдвэрлэгч аж ахуйн байгууллага нь үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд GPM ба үйлдвэрлэлийн чанарын удирдлагад тохируулан хувийн хяналт шалгалт явуулах ба хувийн хяналт шалгалтын тайлангаа мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад хүргүүлнэ.

Бүлэг 5: Хүнсний хяналт шалгалт

84 дүгээр зүйл.

Хүнсний шинжилгээний агентлагууд нь Төрийн шаардлага, гэрчилгээ, магадлан итгэмжлэлийн дагуу, бусад хуулиудад өөрөөр заагаагүй бол, итгэмжлэгдсэний дараагаар хүнсний шинжилгээг явуулж болно.

Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас хүнсний шинжилгээний агентлагуудыг магадлан итгэмжлэх нөхцөл, шалгах аргыг тогтооно.

Уг хуулийн дагуу Хүнсний шинжилгээний агентлагуудаас гаргасан шинжилгээний тайлангууд нь мөн ижил үр нөлөөтэй байна.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны захиргааны байгууллагууд хүнсний шинжилгээний бүх эх үүсвэрүүдийг нэгтгэж уг эх үүсвэрүүдийн мэдээллийг хуваалцана.

85 дугаар зүйл.

Хүнсний шинжилгээний агентлагаас томилсон байцаагч хүнсний шинжилгээг бие дааж гүйцэтгэнэ.

Байцаагч нь хууль, журмууд, хүнсний аюулгүй байдлын стандарт болон шалгалт хяналт, шинжилгээний аргуудад суурилан хүнсийг шинжилнэ.

Байцаагч нь шинжлэх ухааны дагуу, мэргэжлийн ёс зүйтэйгээр шинжилгээний мэдээлэл болон дүгнэлтүүдийн үнэн зөв, шударга байдлыг хангаж ажиллана. Хуурамч хяналт, шинжилгээний тайлан гаргахыг хориглоно.

86 дугаар зүйл.

Хүнсний шинжилгээний ажиллагааг хүнсний шинжилгээний агентлаг болон байцаагч хариуцна. Хүнсний шинжилгээний тайлан нь хүнсний шинжилгээний агентлагийн албан ёсны тамгаар тамгалсан, байцаагчийн гарын үсэг эсвэл тамгаар баталгаажсан байна. Хүнсний шинжилгээний тайлангийн хариуцлагыг хүнсний шинжилгээний агентлаг болон байцаагч хүлээнэ.

87 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь хүнсний дээж авч шинжилгээ хийх ажлыг тогтмол хийх буюу хүссэн үедээ шинжилгээний үр дүнг холбогдох зүйл заалтын дагуу нийтэлж болно, ямар ч хүнсэнд шинжилгээний чөлөөлөлт хийж болохгүй. Уг байгууллага нь дээжийг шинжлэхдээ дээжийн үнийг төлөх ба шинжилгээний төлбөр хураамж авахгүй. Уг хуулийн шаардлагуудыг хангасан хүнсний шинжилгээний агентлагуудыг хүнсний шинжилгээ хийхэд итгэмжилж, хөлслөн ажиллуулж болно. Хүнс үйлдвэрлэгчид, нийлүүлэгчдээс шинжилгээний болон бусад төлбөр авахгүй.

88 дугаар зүйл.

Энэ хуульд заасан шинжилгээний үр дүнгийн талаархи маргаан гарсан тохиолдолд хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчид нь уг үр дүнг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор тухайн дээжний хяналт шалгалтыг явуулсан Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад өргөдөл гаргах буюу түүний дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргана. Уг өргөдлийг хүлээн авсан тохиолдолд дахин шинжилгээг хийх агентлагийг жагсаалтанд буй дахин шинжилгээ явуулах агентлагуудаас санамсаргүй байдлаар сонгон тодорхойлно. Дахин шинжилгээ явуулсан агентлагаас гаргасан дахин

шинжилгээний үр дүн нь эцсийн хяналтын шийдвэр болно. Урьдчилсан шинжилгээ болон дахин шинжилгээг явуулж буй агентлаг нь нэг агентлаг байж болохгүй. Төрийн зөвлөлийн харьяа Гэрчилгээ, магадлан итгэмжлэлийн хяналтын байгууллага, Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага болон Хөдөө аж ахуйн байгууллагаас хамтарч дахин шинжилгээ явуулах агентлагуудын жагсаалтыг гаргана.

Хүнсэнд хэрэглэж болохуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Төрөөс тогтоосон түргэвчилсэн шинжилгээний аргаар хийсэн спот шинжилгээний үр дүнгийн талаар маргаан гарсан тохиолдолд Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь уг үр дүнг хүлээн авснаас хойш 4 цагийн дотор дахин шинжилгээ хийлгэх өргөдөл гаргана. Дахин шинжилгээг түргэвчилсэн шинжилгээгээр явуулж болохгүй.

89 дүгээр зүйл.

Хүнсний үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэж буй хүнсний шинжилгээг хийж болох ба уг хуулийн шаардлагуудыг хангасан, итгэмжлэгдсэн шинжилгээний агентлагуудаар шинжилгээг хийлгэж болно.

Хүнсний аж үйлдвэрийн холбоо, Хэрэглэгчдийн холбоо эсвэл хэрэглэгч хүнсний шинжилгээ хийлгэхийг хүссэн тохиолдолд шинжилгээ хийх агентлагийг уг хуулийн шаардлагуудыг хангасан хүнсний шинжилгээний агентлагуудаас сонгох эрхтэй.

90 дүгээр зүйл.

Хүнсний нэмэлтүүдэд шинжилгээ хийхэд энэ хуульд заасан хүнсний шинжилгээний тухай заалтыг мөрдөнө.

Бүлэг 6: Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импорт

91 дүгээр зүйл.

Импортоор орж ирсэн болон экспортоор гадагш гаргаж буй хүнсний хяналт шалгалтыг төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээрийн байгууллагаас хэрэгжүүлнэ.

92 дугаар зүйл.

Импортоор орж ирж буй хүнс, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүн нь Хятад Улсын үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн байх ёстой.

Импортоор орж ирсэн хүнс, хүнсний нэмэлтүүдийг холбогдох хууль, удирдлагын дүрмүүдийг баримтлан төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагаас хянаж шалгана.

Импортоор орж ирсэн хүнс, хүнсний нэмэлтүүд нь төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагын шаардлагын дагуу чанарын гэрчилгээтэй байх ёстой.

93 дугаар зүйл.

Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг хангах боломжгүй гадаадын экспортлогчид, гадаадын үйлдвэрлэгч аж ахуйн байгууллагуудаас хүнс импортлох тохиолдолд тэдний итгэмжлэгдсэн импортлогчид өөрсдийн хэрэгжүүлж буй үндэсний /бүсийн/ стандарт буюу олон улсын стандартыг Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагад илгээнэ. Төрийн зөвлөлийн харьяа эрүүл мэндийн байгууллагаас холбогдох стандартыг нягтлан шалгаж, хүнсний аюулгүй байдлын шаардлагуудад нийцсэн тохиолдолд тур хугацаанд уг стандартыг хэрэглэх эсэхийг шийдвэрлэнэ. Түүнчлэн, тэд холбогдох үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартыг тухай бүр боловсруулах шаардлагатай. Шинэ хүнсний түүхий эдээр хийсэн хүнсний импорт болон хүнсний нэмэлтүүдийн шинэ төрөл буюу хүнсний хамааралтай бүтээгдэхүүн импортлоход 37 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

Төрийн зөвлөлийн харьяа оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь уг заалтын өмнөх хэсэгт дурьдсан хүнс, хүнсний нэмэлт болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу хянаж шалгах ба хяналтын үр дүнг нийтэд ил тод байршуулна.

94 дүгээр зүйл.

Гадаадын экспортлогчид, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нь Хятад Улсад хүнс, хүнсний нэмэлтүүд, хүнсний хамааралтай бүтээгдэхүүн экспортлохдоо уг хуульд болон Хятад Улсын бусад хууль, үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт зэрэг удирдлагын дүрмүүдэд нийцүүлж, шошго, зааварчилгаан дээрх агуулгын хариуцлагыг хүлээнэ.

Импортоор бараа оруулагчид нь гадаадын экспортлогчид, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд зориулсан уг заалтын өмнөх хэсэгт дурьдсан агуулгын дагуу хяналтын тогтолцоог бий болгоно. Хяналт шалгалтын шаардлага хангаагүй хүнс, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэхийг хориглоно.

Импортоор бараа оруулагчид нь оруулж ирж буй хүнс нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй эсвэл хүний эрүүл мэндэд аюул учруулж болохуйц гэдгийг олж мэдсэн бол уг хүнсийг импортлохоо тэр даруй зогсоож 63 дугаар зүйлд заасны дагуу буцаан таталт хийнэ.

95 дугаар зүйл.

Гадаадад илэрсэн хүнсний аюулгүй байдлын асуудал нь Хятад Улсад нөлөөлж болзошгүй нөхцөлд эсвэл хүнсний аюулгүй байдлын томоохон асуудал импортоор орж ирсэн хүнс, хүнсний нэмэлт, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнд илэрсэн тохиолдолд төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь эрсдлийн сэрэмжлүүлэг гаргах буюу хяналтын арга хэмжээг даруй авч Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага болон Хөдөө аж ахуйн байгууллагад мэдэгдэнэ. Эдгээр газрууд нь мэдэгдлийг хүлээн авсан даруйдаа холбогдох арга хэмжээг авна.

Мужийн түвшний болон дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь дотоодын зах зээлд худалдаалагдаж буй импортоор оруулж ирсэн хүнс, хүнсний нэмэлт, хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийг хянаж шалгана. Хүнсний аюулгүй байдлын ноцтой асуудал илэрсэн тохиолдолд Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь тэр даруй төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагад мэдэгдэж шилжүүлнэ. Төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь холбогдох арга хэмжээг нэн даруй авна.

96 дугаар зүйл.

Гадаадын экспортлогчид буюу Хятад Улс руу хүнс экспортолж буй агентууд болон хүнс импортоор оруулж ирж буй импортлогчид нь төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагад бүртгэл хийлгэсэн байх ёстой. Хятад Улс руу хүнс экспортолж буй гадаадын хүнс үйлдвэрлэгчид нь төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагад бүртгүүлсэн байх ёстой. Хэрэв бүртгэлтэй, гадаадын хүнс үйлдвэрлэгч аж ахуйн байгууллага нь хуурамч мэдээлэл өгсөн буюу импортлосон хүнс нь хүнсний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц асуудал үүсгэсэн бол төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь уг бүртгэлийг цуцалж, холбогдох мэдэгдлийг хийнэ.

Төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагад бүртгэгдсэн буюу жагсаалтад бүртгэлтэй гадаадын экспортлогчид, агентууд, импортлогчид болон гадаадын хүнс үйлдвэрлэгчдийн жагсаалтыг тогтмол нийтэлж, шаардлагатай мэдээллийг нийтэд түгээнэ.

97 дугаар зүйл.

Импортоор оруулж ирж буй урьдчилан савласан хүнсний шошго, зааварчилгаа нь Хятад хэл дээр байх ба Хятад Улсын хууль, зааварчилгаанд шаардлагатай гэж заасан нэмэлт тайлбарыг Хятад хэл дээр орчуулна. Шошго, зааварчилгаа нь уг хууль, Хятад Улсын бусад хууль, удирдлагын дүрмүүд болон хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн, гарал үүслийн улс, дотоодын агентын нэр, хаяг, холбоо барих мэдээллийг заасан байна. Урьдчилан савласан

хүнсний, шошго, зааварчилгаа нь Хятад хэл дээр бичигдээгүй буюу шошго, зааварчилгаа нь хуульд нийцээгүй хүнсийг импортлохыг хориглоно.

98 дугаар зүйл.

Хүнс импортоор оруулагчид нь импортолсон, борлуулсан хүнс, хүнсний нэмэлт, хүнсний хамааралтай бүтээгдэхүүний нэр, зориулалт, хэмжээ, үйлдвэрлэсэн огноо, үйлдвэрлэсэн буюу импортлосон сериал дугаар, хадгалах хугацаа болон экспортлогч, худалдан авагчийн нэр, холбоо барих мэдээлэл ба хүргэлтийн огноо зэргийг багтаасан бүртгэл боловсруулах ба холбогдох итгэмжлэлийн бичгийг хадгалж болно. Уг бүртгэлүүд болон итгэмжлэлүүдийг хадгалах хугацаа нь уг хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу байна.

99 дүгээр зүйл.

Экспортын хүнс үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн экспортолж буй хүнс нь импортолж буй улсын /бүсийн/ стандартад нийцсэн буюу гэрээний шаардлагуудыг хангасан байх ёстой.

Экспортолж буй хүнсний үйлдвэрлэгчид болон түүхий эдийн тариалалт, үржүүлгийн талбайн фермүүд нь оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагад бүртгэл хийлгэх ёстой.

100 дугаар зүйл.

Төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь импортолсон, экспортолсон хүнсний аюулгүй байдлын дараах мэдээллийг цуглуулж, нэгтгээд холбогдох газрууд, хүрээлэнгүүд болон аж ахуйн нэгжүүдэд мэдээлнэ:

- i. Оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагаас хийсэн хяналтаар гарсан, импортолсон, экспортолсон хүнсний аюулгүй байдлын тухай мэдээлэл,
- ii. Хүнсний аж үйлдвэрийн холбоо, хэрэглэгчдийн холбоо болон хэрэглэгчдээс мэдээлсэн импортоор орж ирсэн хүнсний аюулгүй байдлын тухай мэдээлэл,
- iii. Олон улсын байгууллагууд болон Гадаад орны засгийн газруудаас гаргасан эрсдлийн урьдчилсан сануулга болон бусад хүнсний аюулгүй байдлын мэдээлэл, Гадаад орны хүнсний аж үйлдвэрийн холбоо болон хэрэглэгчдээс мэдээлсэн хүнсний аюулгүй байдлын тухай мэдээлэл,
- iv. Бусад хүнсний аюулгүй байдлын тухай мэдээллүүд багтана.

Төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь импортлогчид, экспортлогчид болон экспортын хүнс үйлдвэрлэгчдийн зээлийн мэдээллийг боловсруулж, нийтэлнэ. Найдваргүй зээлийн бүртгэлтэй импортлогчид, экспортлогчид болон экспортын хүнс үйлдвэрлэгчдийн хяналт, хорио цээрийг чангатгана.

101 дүгээр зүйл.

Төрийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллага нь Хятад Улсад хүнс экспортолж буй улсуудын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон хүнсний аюулгүй байдлын статусыг хянаж, үнэлж болох ба уг хяналт, үнэлгээний үр дүнд суурилан холбогдох хяналт, хорио цээрийн шаардлагуудыг тогтооно.

Бүлэг 7: Хүнсний аюулгүй байдлын ослын зохицуулалт

102 дугаар зүйл.

Төрийн зөвлөл нь үндэсний хүнсний аюулгүй байдлын осолд зориулсан онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулна.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны захиргааны байгууллагууд нь холбогдох хууль, дүрмүүдэд үндэслэн эрх мэдлийнхээ хүрээнд хүнсний аюулгүй байдлын осолд зориулсан онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны засгийн газрын онцгой байдлын төлөвлөгөө болон орон нутгийн нөхцөл байдлын талаар дээд шатны захиргаанд албан ёсоор бүртгүүлэхээр илгээнэ.

Хүнсний аюулгүй байдлын осолд зориулсан онцгой байдлын төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдлын ослоудад ангилал тогтоосон заалт, байгууллагын эрэлт хэрэгцээний тогтолцоо болон асуудал гарсан үеийн үүрэг, урьдчилан сэргийлэх буюу урьдчилсан сануулгын механизм болон онцгой байдлын эсрэг арга хэмжээ зэргийг тусгасан байна.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчид нь хүнсний аюулгүй байдлын осолд зориулсан хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж, хүнсний аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн талаар тогтмол хяналт явуулах ба хүнсний аюулгүй байдлын учирч болохуйц эрсдлийг арилгах арга хэмжээг цаг хугацаанд нь авна.

103 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын осол болсон байгууллага нь асуудлыг тархахаас сэргийлэх арга хэмжээг нэн даруй авна. Осол илэрсэн байгууллага болон өвчтөнүүдийг хүлээн авч, эмчилж буй байгууллага нь тэр даруй Мужийн түвшний Эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Чанарын хяналтын байгууллага болон Хөдөө аж ахуйн байгууллага нь хүнсний аюулгүй байдлын асуудлыг олж тогтоосон буюу үүний талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараа цаг алдалгүй ижил түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

Хүнсний аюулгүй байдлын асуудал бий болсон тохиолдолд мэдээллийг хүлээн авсан мужийн түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний

хяналтын байгууллага нь онцгой байдлын төлөвлөгөөний дагуу дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдээлнэ.

Мужийн түвшний захиргааны байгууллага болон дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь онцгой байдлын төлөвлөгөөний дагуу дээд эрх мэдэлтнүүдэд мэдэгдэнэ.

Ямар ч албан байгууллага, хувь хүн Хүнсний аюулгүй байдлын ослын талаархи баримтыг нуун дарагдуулж, худал хэлэх буюу саатуулж, дуурайлган хийх эсвэл устгахыг хориглоно.

104 дүгээр зүйл.

Эмнэлгийн байгууллагууд нь хүнсний гаралтай халдварт өвчтэй өвчтөнг олж илрүүлсэн буюу ийм өвчтөн байх магадлалтай үед холбогдох заалтын дагуу Эрүүл мэндийн байгууллагад уг мэдээллийг мэдээлнэ. Хэрэв Эрүүл мэндийн байгууллагаас уг асуудлыг хүнсний аюулгүй байдалтай хамааралтай гэж үзвэл тэр даруй ижил түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Эрүүл мэндийн байгууллагаас хийсэн шинжилгээгээр хүнсний аюулгүй байдалтай хамаатай халдварт өвчин болон нийтийн эрүүл мэндийн гэнэтийн осол гэх мэт мэдээллийг илрүүлсэн бол ижил түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад тэр даруй мэдэгдэнэ.

105 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын ослын тайланг хүлээн авмагцаа, мужийн түвшний болон дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага, Чанарын хяналт болон Хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран уг ослын шинжилгээ судалгаа, зохицуулалтан дээр ажиллаж, олон нийтийг аюулаас урьдчилан сэргийлэх, багасгах дараах арга хэмжээг авна:

- I. Хүнсний аюулгүй байдлын осолд өртсөн хүмүүст зориулсан яаралтай тусламжийг үзүүлэх
- II. Хүнсний аюулгүй байдлын ослыг үүсгэсэн байж болох хүнс, түүхий эдийг битүүмжилж, яаралтай шинжилгээ хийж, хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд бохирдолтой нь баталгаажсан хүнс, түүхий эдийг буцаан татахыг тушаах буюу энэ хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагааг түр зогсоох,
- III. Бохирдсон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнийг битүүмжилж, цэвэрлэх ариутгах үйл ажиллагаа хийхийг тушаах,

- IV. Хүнсний аюулгүй байдлын ослын илрүүлэлт болон эмчилгээний талаархи мэдээллийг зөв зохистойгоор нийтэд хүргэж, болзошгүй аюулыг тайлбарлаж, тодруулах,
- V. Онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай Хүнсний аюулгүй байдлын ослын үед мужийн түвшний захиргааны байгууллагаас хүнсний аюулгүй байдлын ослыг зохицуулах эрх мэдэл бүхий байгууллага томилж, онцгой байдлын төлөвлөгөөг идэвхжүүлж, өмнөх хэсэгт дурьдсаны дагуу ослыг зохицуулна.

Хүнсний аюулгүй байдлын томоохон зөрчил гарсан тохиолдолд мужийн түвшний Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн байгууллагаас холбогдох газруудын тусламжтайгаар газар дээрх эрүүл ахуйн шинжилгээг гүйцэтгэж, хүнсний аюулгүй байдлын осол үүсгэсэн хүчин зүйлсийг өвчний тархвар судлалын судалгаагаар шинжилнэ. Мужийн түвшний Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн байгууллага нь өвчний тархвар судлалын судалгааны тайланг ижил түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Эрүүл мэндийн байгууллагад илгээнэ.

106 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын ослын үед Хотын түвшний Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь дүүргүүд, холбогдох газруудтай хамтран ослын хариуцагч талуудын судалгааг явуулж, холбогдох газруудыг өөрсдийн үүргээ биелүүлэхийг уриалж, хариуцлагын судалгааны тайланг ижил түвшний захиргааны байгууллагад болон дээд шатны Эрүүл мэнд, эм бэлдмэлийн байгууллагад илгээнэ.

Хүнсний аюулгүй байдлын осол хоёроос дээш орон нутаг, автономит бүсүүд болон өөрийн удирдлагатай хотуудыг хамарсан тохиолдолд Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас өмнөх хэсэг дэх заалтын дагуу ослын хариуцагч талыг олж илрүүлэх судалгааг зохион байгуулж явуулна.

107 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын ослын судалгаа нь бодит байдал, шинжлэх ухаанд үндэслэсэн байх ба осол гарсан шалтгааныг богино хугацаанд үнэн зөвөөр тодруулж, хуулийн хариуцлагыг оноож, засаж залруулах арга хэмжээг авна.

Үүнээс гадна, Хүнсний аюулгүй байдлын осол үүссэн байгууллагад оноох хуулийн хариуцлагыг тодорхойлохдоо зохицуулах байгууллагууд, Хүнсний хяналтын агентлагууд, Гэрчилгээний байгууллага болон тэдний ажилтнуудын хяналт шалгалтад хамруулна.

108 дугаар зүйл.

Хүнсний шинжилгээний агентлагуудаас осолтой холбогдох мэдээллийг албан байгууллага, хувь хүнээс олж авч болох буюу холбогдох материал, дээжийг хянуулахаар өгөхийг шаардаж болно. Ийм байгууллага, хувь хүн нь хамтран ажиллаж, шаардсан дээж, материалуудыг хянуулахаар илгээх ёстой.

Хүнсний аюулгүй байдлын ослын шинжилгээний ажиллагаанд ямар ч байгууллага, хувь хүн саад учруулах буюу хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Бүлэг 8. Хяналт шалгалт болон захиргааны үйл ажиллагаа

109 дүгээр зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Чанарын хяналтын байгууллага нь Хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалт, эрсдлийн үнэлгээний үр дүн болон хүнсний аюулгүй байдлын нөхцөлийг үндэслэн эрсдлийн ангиллын удирдлагыг хэрэгжүүлж, Хяналт шалгалтын давамж, гол асуудлууд болон аргыг тодорхойлон ажиллана.

Мужийн түвшний орон нутгийн захиргааны байгууллага нь Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, Чанарын хяналтын байгууллага болон хөдөө аж ахуйн байгууллагуудыг эрх мэдлийнхээ хүрээнд хүнсний аюулгүй байдлын жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж, нийтэд ил тод байхаар зохион байгуулна.

Хүнсний аюулгүй байдлын жилийн хяналт шалгалтын төлөвлөгөө нь дараах асуудлуудад анхаарна:

- i. Нярайн болон хүн амын эмзэг бүлэгт зориулсан үндсэн болон нэмэлт хоол хүнс,
- ii. Эмчилгээний хүнсний нэмэлт, техникийн шаардлага хангасан үйлдвэрлэл болон эмчилгээний хүнсний сурталчлах үйл ажиллагааны шошго, зааварчилгаа, сурталчлах материалууд,
- iii. Өндөр эрсдэл бүхий хүнс үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид болон
- iv. Хүнсний аюулгүй байдлын эрсдлийн хяналтын үр дүнгээс гарсан хүнсний аюулгүй байдлын болзошгүй эрсдлүүд зэрэг болно.

110 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Чанарын хяналтын байгууллага нь Хүнсний аюулгүй байдлын хяналт захиргааны үйл ажиллагааны дагуух өөрсдийн хүлээсэн үүргээ гүйцэтгэж, хүнсний үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн үйл ажиллагааг уг хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж шалгахдаа дараах арга хэмжээг авч болно:

- i. Үйлдвэрлэлийн болон худалдааны газрыг талбай дээрх хяналтад хамруулах,
- ii. Үйлдвэрлэгдэж, худалдаалагдаж буй хүнс, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүдийн дээжийг авч шинжлэх,
- iii. Холбогдох гэрээ, баримт бичиг, тэмдэглэл болон бусад мэдээллийг хянаж, хуулбарлах,
- iv. Хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнс, хүнсний нэмэлтүүд болон хүнсний хамааралтай бүтээгдэхүүнүүд, нуугдмал аюулгүй байдлын эрсдэлтэй буюу баримтаар нотлогдсон хууль бус үйлдвэрлэл нийлүүлэлтэд ашиглагдсан бүтээгдэхүүнүүдийг хураан авч битүүмжлэх,
- v. Хууль бус хүнс үйлдвэрлэл, нийлүүлэлт явуулсан байрнуудыг хаах зэрэг болно.

111 дүгээр зүйл.

Аливаа хүнс нь эрсдлийн үнэлгээгээр аюулгүй байдлын нуугдмал эрсдэлтэй нь нотлогдсон тохиолдолд холбогдох хүнсний аюулгүй байдлын стандартыг өөрчилж боловсруулах үйл ажиллагааг Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага холбогдох газруудтай хамтран үйлдвэрлэл, нийлүүлэлт болон удирдлагад үндэслэн түр зуурын хязгаарлалт тавих, хүнсэнд агуулагдаж буй аюултай бодисын хяналтын аргыг тодорхойлж хүнсний аюулгүй байдлын стандартад нэмэлт өөрчлөлт оруулна.

112 дугаар зүйл.

Хүнсний хяналт, шалгалтын үед Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь Төрөөс тогтоосон түргэвчилсэн шинжилгээний аргаар хийсэн спот хяналтыг гүйцэтгэнэ.

Уг спот хяналтын үр дүнгээр хүнсний бүтээгдэхүүн нь холбогдох хүнсний аюулгүй байдлын стандартад нийцэхгүй байх магадлалтай бол 87 дугаар заалтын дагуу шинжилнэ. Спот шинжилгээний үр дүнгээр аливаа хүнс нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй нь нотлогдвол уг үр дүн нь захиргааны шийтгэл оноох үндэслэл болно. 113 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь нь лиценз олголтын бүртгэл, ердийн хяналт шалгалтын үр дүн, хууль бус үйл ажиллагааны зохицуулалт зэрэг эдгээр мэдээллүүдийг багтаасан хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн хүнсний аюулгүй байдлын өр зээлийн бүртгэлийг бий болгож, эдгээрийг нийтэд ил болгож, хуулийн дагуу байнга шинэчлэн хадгална. Энэ нь найдваргүй зээлийн бүртгэлтэй хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн хяналт шалгалтын давтамжийг хүнсний аюулгүй байдлын өр зээлийн бүртгэлд суурилан өсгөх зориулалттай юм. Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь ноцтой зөрчил гаргасан тохиолдолд,

хөрөнгө оруулалт, аюулгүй байдлын зохицуулалтын алба болон холбогдох Эдийн засгийн байгууллагууд зэрэг эрх бүхий байгууллагаас уг зөрчлийг хянан шийдвэрлэнэ.

114 дүгээр зүйл.

Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь Хүнсний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн үед гарсан нуугдмал хүнсний аюулгүй байдлын эрсдлийг арилгаж чадаагүй тохиолдолд, уг үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, удирдлагатай Мужийн түвшний болон дээд шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас тэдний хариуцлагыг харгалзан ярилцлага хийж болно. Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчид нь тэр даруй засч залруулж, засвар оруулан, эдгээр нуугдмал эрсдүүлийг арилгах арга хэмжээ авна. Уг ярилцлага болон засварлалтын талаар хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн хүнсний аюулгүй байдлын өр зээлийн бүртгэлд оруулна.

115 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Чанарын хяналт шалгалтын байгууллага нь өөрсдийн цахим шуудан, утасны дугаарыг нийтэд ил байршуулж зөвлөгөө, гомдол, мэдэгдлүүдийг хүлээн авна. Хүлээн авсан зөвлөгөө, гомдол, мэдэгдлүүдэд хуульд заасан хугацааны дотор хариу өгч, баталгаажуулж, зохицуулна, тэгээгүй тохиолдолд уг зөвлөгөө, гомдол, мэдэгдлүүдийг эрх мэдэл бүхий зөвлөх, гомдол бүртгэгч, сурвалжлагчдад бичгээр мэдэгдэж шилжүүлнэ. Эрх бүхий байгууллагаас уг зөвлөгөө, гомдол, мэдэгдлүүдийг хуульд заасан хугацаанд зохицуулна. Ирсэн мэдэгдэл нь үнэн зөв болох нь батлагдсан тохиолдолд мэдэгдэл ирүүлсэн мэдүүлэгчийг шагнаж урамшуулна.

Холбогдох газрууд нь уг мэдэгдлүүдийн нууцлалыг хадгалж, мэдүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах ёстой. Уг мэдүүлэгчийн ажил олгогч нь тэдний хөдөлмөр эрхлэлтийн гэрээг цуцлах, өөрчлөх болон бусад байдлаар мэдүүлэгчид арга хэмжээ авах ёсгүй.

116 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Чанарын хяналт шалгалтын байгууллага нь хууль, дүрмүүдийн сургалт, хүнсний аюулгүй байдлын холбогдох стандартуудыг бэхжүүлж, хууль сахиулах албан тушаалтнуудын хууль сахиулах чадавхи, мэргэжлийн мэдлэг болон тэдний үнэлгээг зохион байгуулж, удирдана.

Хүнсний аюулгүй байдлын тухай хууль сахиулахад хамааралтай мэдлэг, чадавхигүй этгээд нь уг үйл ажиллагаанд оролцож болохгүй.

Хүнс үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчид, Хүнсний аж үйлдвэрийн холбоо болон Хэрэглэгчдийн холбооноос Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон Чанарын хяналтын байгууллагад хууль дүрмийг зөрчсөн тохиолдол буюу хүнсний аюулгүй байдлын тухай хууль сахиулах албан тушаалтнуудын хууль бус үйлдлийг мэдэгдэнэ. Гомдол, мэдэгдлийг хүлээн авсан газар буюу эрх бүхий байгууллага нь уг мэдэгдэл гомдлыг шалгаж, баталгаажуулсан мэдээллийг хууль сахиулах албан тушаалтны харьяалагдах газарт мэдэгдэнэ. Хууль, дүрмүүдийг зөрчсөн тохиолдолд тэдгээр албан тушаалтнуудыг энэ хууль болон холбогдох заалтуудыг баримтлан шийтгэнэ.

117 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь хүнсний аюулгүй байдлын эрсдлийн тогтолцоог илрүүлж чадаагүй буюу эрх мэдлийнхээ хүрээнд олгогдсон хугацаанд хүнсний аюулгүй байдлын нуугдмал эрсдлийг арилгаж чадаагүй бол ижил түвшний захиргааны байгууллагаас хуулийн хариуцлага хүлээлгэхээр удирдлагатай нь ярилцлага хийж болно.

Орон нутгийн захиргааны байгууллага нь хүнсний аюулгүй байдлыг хангах үүргээ гүйцэтгэж чадаагүй буюу бүс нутгийн хүнсний аюулгүй байдлын гол эрсдлийг олгосон хугацаанд нь арилгаж чадаагүй бол дээд шатны захиргааны байгууллагаас хуулийн хариуцлага хүлээлгэхээр гол удирдлагатай нь ярилцлага хийж болно.

Ярилцлаганд орсон Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон бусад газрууд, орон нутгийн захиргааны байгууллага нь тэр даруй өөрсдийн Хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалтын ажиллагааг засч залруулах арга хэмжээ авна.

Хүнсний аюулгүй байдлыг хариуцаж буй орон нутгийн түвшний Хяналтын байгууллага болон холбогдох газруудын хяналт, үнэлгээний бүртгэлд ярилцлага болон засварлалтын талаар Хяналт, үнэлгээний бүртгэлд оруулна.

118 дугаар зүйл

Төрөөс хүнсний аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн мэдээллийн платформыг байгуулах, хэвлэн нийтлэх тогтолцоог бий болгоно. Хүнсний аюулгүй байдлын талаар үндэсний ерөнхий хүнсний аюулгүй байдал, эрсдлийн анхааруулга мэдээлэл, голлох хүнсний аюулгүй байдлын осол болон түүний хяналт зохицуулалт болон хэвлэн нийтлэх шаардлагатай бусад мэдээллийг Төрийн зөвлөлөөс гаргасан нэгдмэл арга хэмжээгээр шийдэгдэх, Төрийн зөвлөлийн харьяа нэгдмэл Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас нийтэлсэн байх хэрэгтэй. Хүнсний аюулгүй байдлын талаар эрсдлийн анхааруулгын мэдээллийн нөлөөлөл, голлох хүнсний аюулгүй байдлын осол, тодорхой орон

нутгийн хяналт зохицуулалт болон үүнтэй холбоотой мэдээллийг Төв засгийн газрын харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний орон нутгийн хяналтын байгууллагууд, автономит бүсүүд, өөрөө удирдлагатай хотуудад хүргүүлнэ. Ямар ч мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлэхгүй.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, чанарын хянан шалгалтын байгууллага, хөдөө аж ахуйн байгууллага нь хүнсний аюулгүй байдлын талаар чиг үүргийнхээ дагуу хянан шалгалтын журмын хэвлүүлэн нийтлүүлэх үүрэгтэй.

Хүнсний аюулгүй байдлын талаар хэвлүүлсэн мэдээлэл нь үнэн зөв бөгөөд цаг үеэ олсон, шаардлагатай тайлбар агуулсан буюу хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй, нийтийн үзэл бодолд нөлөөлөхгүй байх ёстой.

119 дүгээр зүйл

Энэ хуульд заасан нэгдсэн нийтлэлийн шаардлагад нийцүүлэн мэдээллийг хүлээн авахдаа харьяа тужийн түвшний болон түүнээс дээш шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын байгууллага, хөдөө аж ахуйн байгууллага нь дээд шатны байгууллагадаа яаралтай мэдэгдэх ба дараа нь Төрийн зөвлөлийн харьяа хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэж хэрэв шаардлагатай бол Төрийн зөвлөлийн харьяа хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад шууд мэдэгдэнэ.

Харьяа мужийн түвшний болон түүнээс дээш шатны өөрөө удирдах байгууллагын хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын байгууллага, хөдөө аж ахуйн байгууллага хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын мэдээллийн журмаа солилцож болно.

120 дугаар зүйл

Аливаа нэгэн албан байгууллага эсвэл хувь хүн хүнсний аюулгүй байдлын талаар мэдээллийг хуурамчаар үйлдэн тарааж болохгүй.

Хэрэглэгчийг төөрөгдүүлэх болон нийтийн санаа бодолд нөлөөлөх хүнсний аюулгүй байдлын талаар мэдээллийг түгээхдээ мужийн болон түүнээс дээш шатны хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага харьяа хэлтэс, агентлаг, холбогдох үйлдвэрлэгч болон нийлүүлэгчийг хэрэгтэй мэдээлэлд дүн шинжилгээ хийлгэх болон дүн шинжилгээний мэдээллийг цагт нь буцаан ирүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

121 дүгээр зүйл

Хүнсний аюулгүй байдалд холбогдох гэмт хэргийг олж илрүүлсэн мужийн түвшний болон түүнээс дээш шатны хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон чанарын хяналт шалгалтын байгууллага нь энэ хэргийг олон нийтийн аюулгүй байдлын байгууллагад шилжүүлнэ. Үүний дараагаар нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллага нь цаг алдалгүй гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тодорхойлж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хэргийг мөрдөн байцаалтын шат руу хүргүүлнэ.

Олон нийтийн аюулгүй байдлыг сахиулагч эрх бүхий этгээд гэмт хэргийн шинж байхгүй эсвэл хөнгөн гэмт хэрэгт тооцогдохоор бол эрүүгийн хариуцлагаас өөр захиргааны хариуцлага тооцон хариуцлага хүлээлгэнэ. Олон нийтийн аюулгүй байдлыг сахиулагч эрх мэдэлтнүүд дээрх тохиолдолд хуульд заасан бол уг хэргийг хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага болон чанарын хяналт шалгалтын байгууллагад шилжүүлнэ.

Олон нийтийн аюулгүй байдлыг сахиулах эрх бүхий этгээд хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, чанарын хяналт шалгалтын байгууллагад болон хүрээлэн буй орчныг хамгаалах байгууллагад хандсан туршилтын үр дүн, хяналт шалгалтын дүгнэлт, хүнсийг сөрөг нөлөөгүй байдлаар устгалд оруулах талаар хүсэлт илгээсэн тохиолдолд тухайн захиргааны байгууллагууд хэрэгцээтэй тусламж дэмжлэгийг үзүүлнэ.

Есдүгээр бүлэг

Хууль зүйн хариуцлага

122 дугаар зүйл.

Хууль бусаар буюу зөвшөөрөлгүйгээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, нийлүүлсэн болоод хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол тухайн хууль бусаар үйлдэрлэсэн, нийлүүлсэн хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт, мөн тэдгээрийг хууль бусаар үйлдэрлэж нийлүүлэхдээ ашигласан багаж, техник хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний түүхий эд зэрэг хууль бусаар олсон орлогыг харьяа мужийн Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авч хураагдсан бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 ₮-аас ихгүй бол 50,000-100,000 ₮-тай тэнцэх хэмжээгээр, уг барааны нийт үнэ 10,000 ₮-аас их бол дээр дурьдсан дүнг 10-аас 20 дахин нэмэгдүүлэн торгоно.

Дээр дурьдсан хууль бус үйлдлийг үйлдэхэд зөвшөөрөл олгосон болон хууль бус үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдлыг бүрдүүлж өгсөн этгээдийн үйлдлийг таслан зогсоохоор хууль бус орлогыг мужийн түвшний болон түүнээс дээш шатны Хүнсний бүтээгдэхүүн болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авах ба 50,000-аас 100,000 ₮-аар торгоно. Тус хууль бус үйлдлээс болоод худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол учирсан бол уг хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгч этгээд бие даан болон хамтран хариуцлага хүлээж хохирлыг барагдуулна.

123 дугаар зүйл.

Гэмт хэрэг үйлдэхгүйгээр хууль зөрчиж, доорх зөрчлүүдийг гаргасан этгээдэд хууль бус ашиг сонирхолынх нь төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх ба хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, түүхий эдийг хууль бусаар техник хэрэгсэл ашиглан үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн, хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг хууль бусаар бэлтгэсэн болон нийлүүлсэн этгээдийн хууль зөрчин олсон орлогыг харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авч хураагдсан нийт бараа бүтээгдэхүүний үнийн дүн 10,000 ₮-аас бага бол 100,000-аас 150,000 ₮-тай тэнцэх хэмжээгээр, уг бараа бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 ₮-аас их бол дээрх дүнг 15-30 дахин нэмэгдүүлэн торгоно. Онцгой тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн лицензийн эрхийг цуцлах болон шууд удирдаж байгаа захиралд төдийгүй оролцсон хүн нэг бүрт хариуцлага хүлээлгэж нийтийн аюулгүй байдлыг сахиулах үүднээс 5-15 хоног баривчлана :

- i. Хүнсний бус түүхий эдээр хийсэн хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээс бусад, хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй байж болзошгүй химийн бодисууд болон бусад бодисуудыг нэмсэн, дахин

- боловсруулсан хүнсийг хүнсний түүхий эд болгож ашигласан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эсвэл нийлүүлсэн,
- ii. Нярайн болон эмзэг бүлгийн хүн амын үндсэн болон нэмэлт хүнсний шим тэжээлийн бодисын найрлага нь хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөөгүй буюу дордуулсан үндсэн ба нэмэлт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эсвэл нийлүүлсэн,
 - iii. Халдварт өвчин, хор эсхүл тодорхойгүй шалтгааны улмаас үхсэн шувуу, мал, амьтан, усны амьтдын мах махан бүтээгдэхүүн болон түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эсвэл нийлүүлсэн,
 - iv. Хорио цээр тогтоосон газраас бэлтгэсэн болон зохих ёсны хяналт шалгалтанд ороогүй болон зохих ёсны хяналт шалгалтаас шаардлагатай үнэлгээ аваагүй газраас бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг нийлүүлсэн,
 - v. Өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрөөс зарж борлуулахыг илт хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлсэн,
 - vi. Эмийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эсвэл нийлүүлсэн тохиолдлууд хамаарна.

Дээрх зөвшөөрөлгүйгээр буюу хууль бусаар хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон нийлүүлэх үйл ажиллагаанд хамтран оролцсон этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсоож, хууль бусаар олсон орлогыг харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авч 100,000-аас 200,000 ₮-тай тэнцэх хэмжээний дүнгээр торгоно. Уг хууль бус ажиллагааны нөлөөгөөр худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсэн бол уг хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгч этгээд бие даан болон хамтран хариуцлага хүлээж хохирлыг арилгана.

Хуулиар оноосон ялаас гадна ноцтой их хэмжээгээр болон их хэмжээний пестицидийг хууль бусаар ашигласан этгээдийг дээр дурьдсан 1-р хэсгийг үндэслэн нийтийн аюулгүй байдлын үүднээс баривчлах ял шийтгэж болно.

124 дүгээр зүйл.

Доорх хууль бус үйлдлүүд нь гэмт хэргийн шинжгүй боловч зөрчилд тооцогдохоор бол хууль бусаар үйлдвэрлэсэн үйлдвэрлэгч, нийлүүлэгчид хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлтийг хууль бусаар техник хэрэгсэл ашиглан үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн, хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг хууль бусаар бэлтгэсэн болон нийлүүлсэн этгээдийн хууль бусаар олсон орлогыг харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авч хураагдсан нийт бараа бүтээгдэхүүний үнийн дүн 10,000 ₮-аас бага бол 50,000-100,000 ₮-тай тэнцэх хэмжээгээр, уг бараа бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 ₮-аас их бол дээрх дүнг 10-20 дахин нэмэгдүүлэн торгох болон

онцгой тохиолдолд тухайн байгууллагын лицензийг цуцлах хүртэл арга хэмжээ авна :

- i. Хүнсний аюулгүй байдлын стандартаас хэтэрсэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эмгэг төрүүлэгч бичил биетэн, пестицидийн үлдэгдэл, эмийн гаралтай бүтээгдэхүүний үлдэгдэл, хүнд металл, бохирдуулагч бодис зэргийг агуулсан хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- ii. Хугацаа нь дууссан түүхий эдээр бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- iii. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг зохих ёстой хэмжээнээс хэтрүүлэн агуулсан хүнсийг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- iv. Ялзарч муудсан болон өөх тос ихээр агуулсан, хөгц, шавжны нөлөөгөөр эсвэл гадаад орчны ямар нэг шалтгаанаар бохирдсон, мэдэгдэхүйцээр энгийн байдлаа алдсан ба бохирдсон хүнсийг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- v. Хуурамчаар үйлдвэрлэсэн огноо болон шошгийг өөрчлөн үйлдвэрлэсэн эсвэл барааны хадгалах хугацааг хууль бусаар уртасгасан шошго наасан хүнсийг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- vi. Бүртгэлд бүртгэгдээгүй эсвэл бүртгүүлэхэд шаардлагатай жор болон үйлдвэрлэлийн процессын шаардлага хангаагүй эрүүл мэндэд тустай хүнс, эмийн зориулалттай хүнс, нярайн хуурай сүүг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн,
- vii. Адилхан байгууллага, аж ахуй нэгжийн үйлдвэрлэсэн нярайн хуурай сүүг хольж болон нэг үйлдвэрлэгчийн нэг жороор үйлдвэрлэсэн өөр чанартай нярайн хуурай сүүг үйлдвэрлэсэн,
- viii. Тухайн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхдээ хүнсний аюулгүй байдлын үнэлгээний шаардлага хангаагүй шинэ түүхий эд эсвэл шинэ хүнсний нэмэлт бүтээгдэхүүн ашиглан үйлдвэрлэсэн,
- ix. Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас шаардсан боловч үйл ажиллагаагаа зогсоох болон хүчингүй болгохоос татгалзсан тохиолдлууд хамаарна.

123 дугаар зүйл болон 125 дугаар зүйлд заагдсанаас өөрөөр хүнсний аюулгүй байдлын стандартыг зөрчин хууль бусаар хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн этгээдээд дээр дурьдсан арга хэмжээг авна.

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээний шаардлага хангаагүй шинэ төрлийн хүнсний холбогдолтой бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлага хангаагүй этгээдийг 1 дүгээр хэсэгт үндэслэн мужийн захиргааны байгууллагын харьяа хяналтын байгууллагаас ял оноож болно.

125 дугаар зүйл.

Доорх нөхцлүүдээр хууль зөрчин хууль бус үйл ажиллагаа явуулсан үйлдвэрлэгч, нийлүүлэгчид хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хууль бусаар техник хэрэгсэл ашиглан үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн, хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг хууль бусаар бэлтгэсэн болон нийлүүлсэн этгээдийн хууль бусаар олсон орлогыг харьяа мужийн Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хураан авч хураагдсан нийт бараа бүтээгдэхүүний үнийн дүн 10,000 ₮-аас бага бол 5,000-50,000 ₮-тай тэнцэх хэмжээгээр, уг бараа бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 ₮-аас их бол дээрх дүнг 5-10 дахин нэмэгдүүлэн торгох болон онцгой тохиолдолд тухайн байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоох болон лицензийг цуцлах хүртэл арга хэмжээ авна :

- i. Сав, баглаа боодлын материал, хадгалах савны нөлөөгөөр болон тээвэрлэх явцад бохирдсон хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн,
- ii. Шошгогүй буюу бүрэн савлагдаагүй болон хуулийн дагуу заавар болон шошго наагаагүй хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн буюу нийлүүлсэн,
- iii. Шаардлагын дагуу тэмдэглэгээ хийгээгүй генийн өөрчлөлттэй хүнсийг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн ба
- iv. Хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнсний материал, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн эсвэл хүнсний холбогдолтой бүтээгдэхүүн худалдсан эсвэл ашигласан тохиолдлууд хамаарна.

Хэрэв үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний шошго болон зааварчилгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй алдаатай эсвэл худалдан авагчийг илт төөрөгдүүлсэн байвал харьяа мужийн Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид засахыг даалгах үүрэгтэй бөгөөд эсэргүүцсэн этгээдийг 2,000 ₮-аас багагүй хэмжээгээр торгоно.

126 дугаар зүйл.

Доорх нөхцлүүдээр хууль зөрчин хууль бус үйл ажиллагаа явуулсан үйлдвэрлэгч, нийлүүлэгчид харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас гаргасан шаардлага эсвэл анхааруулгын дагуу засах үүрэгтэй. Хэрэв засахаас татгалзвал 5,000-50,000 ₮-аар торгох болон онцгой тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох, лицензийг цуцлах хүртэлх арга хэмжээг авна :

- i. Хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгч этгээд худалдан авсан хүнсний материал, үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээ шалгуулах явцад зөрчил илэрсэн,

- ii. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчид шаардлагатай хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлээгүй эсвэл хүнсний аюулгүй байдлын менежерийг бэлтгэх, сургалт явуулах, үнэлэх явцын шаардлага хангаагүй,
- iii. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдийн бүтээгдэхүүн тусгай зөвшөөрөл болон холбогдох худалдан авалтын гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг хангаагүй, эсвэл худалдан авалтын хяналтын тэмдэглэл болон өмнөх үйлдвэрлэлийн хяналтын тэмдэглэл болон борлуулалтын бүртгэлийн тогтолцоо бүрдүүлэхдээ алдаа гаргасан,
- iv. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчид ослын үед хэрэгжүүлэх хүнсний аюулгүй байдлын төлөвлөгөө гаргаагүй,
- v. Шууд хэрэглээнд ашиглах хоол хүнс хадгалах сав, агуулах нь цэвэрлэгдээгүй, ариутгагдаагүй эсвэл цэвэрлэсэн ариутгагдсан байдал нь шаардлагад нийцээгүй эсвэл нийтийн хоолны үйлчилгээний газрын тоног төхөөрөмж нь цэвэрлэгдэж шалгагдаагүй,
- vi. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдийн эрүүл мэндийн шаардлага хангаагүй хүнтэй гэрээ хийсэн эсвэл Төрийн зөвлөлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон хүнсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц халдварт өвчинтэй хүнтэй гэрээ хийсэн бол,
- vii. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчид хүнсний бүтээгдэхүүнийг шаардлагын дагуу нийлүүлж чадаагүй,
- viii. Эрүүл мэндэд тустай хүнс үйлдвэрлэгчид Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагад бүртгүүлээгүй, эсвэл техникийн шаардлага, бүтээгдэхүүний жор эсвэл үйлдвэрлэлийн процессын буюу үйлдвэрлэлийн зохион байгуулалтын шаардлага хангаагүй,
- ix. Нярай хүүхдийн хүнс үйлдвэрлэгчид, хүнсний бүтээгдэхүүний түүхий эд, хүнсний нэмэлт, бүтээгдэхүүний найрлага, үйлдвэрлэлийн процессын ажиллагааг бүртгүүлээгүй,
- x. Онцгой хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн чанарын удирдлагын тогтолцоо бий болгоогүй, түүний үр нөлөөтэй байдлыг зохих түвшинд хангаж чадаагүй, эсвэл хувийн шалгалтын тайлангаа мэдүүлээгүй,
- xi. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчид хүнсний аюулгүй байдлын хувийн хяналт шалгалт хийгээгүй, эсвэл үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн ямар нэгэн өөрчлөлтийн үед зохих хэмжээнд арга хэмжээ авч чадаагүй,
- xii. Сургууль, цэцэрлэг, асрамжийн газар болон барилгын ажил эрхэлдэг төвлөрсөн байгууллагууд хүнсний аюулгүй байдлын удирдлагын үүргээ биелүүлээгүй,
- xiii. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон нийтийн хоолны үйлчилгээ үзүүлэгч этгээд үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн үйл ажиллагаанд

хяналт тавих процесс бий болгоогүй, хэрэгжүүлээгүй тохиолдлууд хамаарна.

Төвлөрсөн ариутгалын үйлчилгээг үзүүлэхдээ ус, угаалгын нунтаг, ариутгалын бодисыг энэ хуулийг зөрчиж ашигласан, эсвэл авч явах зориулалт бүхий хадгалах савыг зохих ёсоор шалгаагүй эсвэл ариутгалын гэрчилгээгүй, эсвэл тусдаа савалгаан дээр нь хамааралт хэсгүүдийг заагаагүй бол харьяа мужийн болон түүнээс дээш шатны Эрүүл мэндийн байгууллага өмнөх хэсэгт дурьдсаныг үндэслэн шийтгэл оногдуулах боломжтой.

Хүнстэй холбоотой бүтээгдэхүүн үйлдвэрлэгч этгээд уг бүтээгдэхүүнээ шалгаагүй тохиолдолд 1-р хэсэгт заасныг үндэслэн мужийн захиргааны байгууллагын харьяа чанарын хяналтын байгууллага шийтгэл оногдуулна.

Хүнстэй холбоотой бүтээгдэхүүн ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэгч 65-р зүйлийг зөрчсөн бол 1-р хэсэгт заасныг үндэслэн харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний захиргааны байгууллага шийтгэл оногдуулна.

127 дугаар зүйл.

Жижиг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг цех болон хүнсний бүтээгдэхүүн борлуулагчдын хууль бус үйлдэлд нь Төв засгийн газрын харьяа орон нутгуул, автономит бүсүүд болон хотын өөрөө удирдах байгууллагуудын зүгээс шийтгэл оногдуулж болно.

128 дүгээр зүйл.

Аливаа зөрчил гарсаны дараа хууль зөрчсөн нь тогтоогдсон бол зохих ёсоор мэдээлж тайлагнаагүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон нийлүүлэгч эрх бүхий субъектэд холбогдох эрх бүхий байгууллага өөрийн үүрэг хариуцлагын хүрээнд алдаагаа засахыг үүрэгдэж сануулга хүргүүлнэ. Хэрэв дээрх субъектүүд үйл ажиллагаагаа нуун далдлах, хуурах, нотлох баримтыг устгасан бол үйлдвэрлэлт болон нийлүүлэлийг түр зогсоох болон 100,000-500,000 ₮-аар торгох ба зарим тохиолдолд олгосон лицензийг цуцлах хүртэлх арга хэмжээг авна.

129 дүгээр зүйл.

Ямар нэгэн хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгч нь доорх нөхцөл байдалд Зах зээлийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагаас 124-р зүйлд үндэслэн шийтгэл оногдуулж болно. Үүнд :

- i. Худал материал бүрдүүлж өгсөн, Хятадын үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнстэй холбоотой бүтээгдэхүүн импортлосон,

- ii. Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт үйлчлэх боломжгүй хүнсийг импортлосон, хэрэглэж болох стандартыг мэдүүлээгүй, тэдгээрийг Төрийн зөвлөлийн Эрүүл мэндийн байгууллагаар шалгуулахдаа эсвэл шинэ хүнсний түүхий эд болон шинэ төрлийн хүнсний нэмэлт эсвэл хүнстэй холбоотой бүтээгдэхүүн импортлохдоо аюулгүй байдлын үнэлгээний шаардлагыг хангаагүй,
- iii. Энэ хуулийг зөрчсөн хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох,
- iv. Хуулийн дагуу эрх баригчдын шаардсанаар импортлогчийн импортлосон хүнсийг буцаан татаас татгалзсан.

Импортлогч этгээд хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний борлуулалтын бүртгэлийн тогтолцоо, гадаадын экспортлогч этгээд эсвэл үйлдвэрлэгч этгээдийн шалгалтын тогтолцоо бий болгож тогтворжуулж чадаагүй бол Зах зээлийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагаас 126 дугаар зүйлд үндэслэн шийтгэл оногдуулна.

130 дугаар зүйл.

Төвлөрсөн худалдааны байгууллагууд, түрээслэгчид, худалдааны үзэсгэлэн худалдаа зохион байгуулагчид нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх, нийтийн хоол нийлүүлэх тусгай зөвшөөрөлгүй хүнсний нийлүүлэгчдийг зах зээлд хүнс худалдахыг зөвшөөрч энэхүү хуулийг зөрчсөн, эсвэл хяналт шалгалт хийх, тайлагнах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага засахыг шаардах, хууль бусаар олсон орлогыг хураан авахын зэрэгцээ 50,000-аас 200,000 ₮-тай тэнцэх хэмжээний дүнгээр торгох, уг үйл ажиллагааны үр дүнд ноцтой үр дагавар үүсгэсэн алдаагаа засахаас татгалзсан буруутай этгээдийн лицензийг цуцлана. Уг хууль бус ажиллагааны нөлөөгөөр худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсэн бол тухайн үйл ажиллагаа эрхлэгч болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бие даан болон хамтран хариуцлага хүлээж хохирлыг арилгана.

Хүнсний хэрэгцээний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бөөний зах зээл эрхлэхдээ дээр дурьдсан 64-р зүйлийг зөрчин үйл ажиллагаа явуулсан этгээдэд хариуцлага оногдуулна.

131 дүгээр зүйл.

Хэрэв цахим хүнсний худалдааны талбар хариуцсан гуравдагч этгээд нэвтрүүлсэн нийлүүлэгчдийнхээ жинхэнэ нэрээр бүртгээгүй, тэдний лицензийг хянан шалгаагүй, тайлагнах үүргээ биелүүлээгүй бол харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас хууль зөрчин явуулж байгаа үйл ажиллагааг зогсоох, зөрчлийг арилгахыг шаардах, хууль бус орлогыг хураан авах ба 50,000-200,000 ₮-аар торгох болон уг үйл ажиллагааны үр дүнд ноцтой үр дагавар үүсгэсэн алдаагаа засахаас татгалзсан буруутай этгээдийн лицензийг цуцлана. Уг хууль бус

ажиллагааны нөлөөгөөр худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол тухайн үйл ажиллагаа эрхлэгч болон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бие даан болон хамтран хариуцлага хүлээж хохирлыг арилгана.

Гуравдагч талын цахимаар худалдаж байгаа бүтээгдэхүүнийг худалдан авах явцад худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол хүнсийг нийлүүлсэн болон үйлдвэрлэсэн этгээдэд хандан нэхэмжлэл гарган нөхөн төлбөр олгохыг шаардах эрхтэй. Хэрэв уг харилцааны гуравдагч тал шаардлагатай нэр, хаяг, холбоо барих дугаарыг өгөөгүй бол нөхөн төлбөрийг төлөх хариуцлага хүлээнэ. Үүний дараа цахим хүнсний худалдааны гуравдагч тал нь уг хохирлоо тухайн үйлдвэрлэгч болон нийлүүлэгч этгээдээр нөхөн төлүүлэх боломжтой. Үйлчилгээ үзүүлэгч нь худалдан авагч буюу хэрэглэгчдийг дэмжсэн аливаа үүрэг амлалт өгсөн бол түүнийгээ биелүүлсэн байх шаардлагатай.

132 дугаар зүйл.

Ямарваа нэгэн байгууллага, албан байгууллага хүнсний хадгалалт, тээвэрлэлт, ачих болон буулгах үйл ажиллагааг хууль зөрчин явуулсан бол харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас хууль зөрчин явуулж байгаа үйл ажиллагааг зогсоох, нэн даруй зөрчлийг арилгахыг шаардах, анхааруулга өгнө. Алдаагаа залруулахаас татгалзсан бол 10,000-50,000 ₮-тай тэнцэх хэмжээгээр торгох, онцгой тохиолдолд лицензийн цуцлах арга хэмжээ авна.

133 дугаар зүйл.

Харьяа хэлтэс, эрх мэдэлтнүүдээс хэрэгжүүлж байгаа хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалтын үйл ажиллагаа, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, эрсдлийн хяналт болон эрсдлийн үнэлгээ хийхэд татгалзсан хариу өгсөн, саад болсон эсвэл хөндлөнгөөс оролцсон этгээдийн үйл ажиллагааг зогсоож 2,000-50,000 ₮-аар торгох ба онцгой тохиолдолд олгосон лицензийг цуцлана. Энэ нь нийтийн аюулгүй байдлын зохицуулалтыг зөрчиж байвал уг шийтгэлийг харьяа нийтийн аюулгүй байдлын эрх мэдэлтнүүд хэрэгжүүлнэ.

Хөдөлмөрийн гэрээг цуцлах эсвэл өөрчлөх эсвэл энэхүү хуулийг зөрчсөн өөр бусад аргаар шалгалтын үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага оногдуулна.

134 дүгээр зүйл.

Үйл ажиллагаагаа цуцлуулах болон нэг жилд нийт 3 удаа лицензээ цуцлуулахаас өөрөөр шийтгүүлж байсан ямар нэгэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчдийн үйл ажиллагаагаа зогсоох ба лицензийг цуцлах эсэхийг Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний захиргаанаас шийдвэрлэнэ.

135 дугаар зүйл.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон нийлүүлэгч байгууллагын лицензийг цуцалсан бол түүний хууль ёсны төлөөлөгчид, удирдаж байгаа болон бусад захирлууд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон нийлүүлэх зөвшөөрөл хүсэх, хүнсний үйлдвэрлэл нийлүүлэлт эрхлэх, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт нийлүүлэлтийн аюулгүй байдал хариуцсан менежерээр ажиллах боломжгүй.

Хүнсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас ял шийтгүүлсэн хүмүүс хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нийлүүлэлт эрхлэх эсвэл хүнсний аюулгүй байдлын менежерээр ажиллаж болохгүй.

Дээрх 2 зүйлийг зөрчсөн ажилтанг ажиллуулж байгаа хүнсний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн лицензийг харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллагаас цуцлана.

136 дугаар зүйл.

Энэхүү хуулиар худалдан авсан хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид хүнсний зүйлийг шалгах үүргээ гүйцэтгэсэн, худалдан авсан хүнсний бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй нь хангалттай нотлох баримтаар нотлогдоогүй, эх сурвалжийг үнэн зөвөөр зааж өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж болох ба хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнсийг нь хурааж авна. Үүнээс үүдэн хувь хүн, түүний эд хөрөнгө болон бусад зүйлд учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

137 дугаар зүйл.

Техникийн хяналтын байгууллагууд болон ажилтнууд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын эрсдлийн хяналт болон эрсдлийн үнэлгээг хийхээ хууль зөрчин худал дүгнэлт, мэдээлэл гаргасан бол удирдах албан тушаалтан буюу захирал болон ажилтанд хуулийн дагуу хариуцлага хүлээж ажлаас чөлөөлөх арга хэмжээ авна. Мөн эрх бүхий байгууллагаас олгосон мэргэжлийн үнэмлэх буюу гэрчилгээг /хэрэв байгаа бол/ нь тухайн олгосон байгууллага цуцлах болно.

138 дугаар зүйл.

Хүнсний хяналтын байгууллага албан тушаалтан хууль зөрчин худал хяналтын тэмдэглэл үйлдсэн тохиролдолд эрх бүхий байгууллага нь олгогдсон мэргэжлийн гэрчилгээг хүчингүй болгож шалгалтын хураамжийн төлбөрийг хураан авч түүнийг 5-10 дахин нэмэгдүүлэн торгох эсвэл 10,000 ₮ болон түүнээс доош бол 50,000 ₮ - 100,000 ₮ дүнгээр торгоно. Удирдах албан тушаалтан буюу захирал болон хүнсний хяналтын байцаагчыг ажлаас нь албадан чөлөөлөх болон ажлаас халах арга хэмжээ авна. Томоохон хэмжээний хүнсний аюулгүй байдлын асуудал тулгарсан үед хүнсний хяналтын байцаагчид хариуцлага тооцон ажлаас нь чөлөөлнө.

Хүнсний хяналтын байцаагч хууль зөрчсөнөөсөө болоод ачлаас чөлөөлөгдсөн байх хугацаандаа ажлаас чөлөөлөх шийдвэр гарснаас хойш 10 жилийн хугацаанд хүнсний хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй. Хүнсний аюулгүй байдал, тайлангийн талаар худал хяналтын дүгнэлт гарган хууль бус үйл ажиллагааны үндсэнд эрүүгийн ял шийтгэгдсэн хүнсний хяналтын байцаагч томоохон хэмжээний хүнсний аюулгүй байдлын асуудал үүсгэсэн бол үлдсэн амьдралынхаа туршид хүнсний хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёсгүй. Хүнсний хяналтын байгууллага хяналтын ажил эрхлэх эрх нь хязгаарлагдсан хүнийг ажилд авч ажиллуулсан бол эрх бүхий байгууллага нь олгогдсон мэргэжлийн гэрчилгээг хүчингүй болгох буюу цуцлана.

Хүнсний хяналтын байгууллагын гаргасан худал хяналт шалгалтын тайлан гаргаснаас үүдэн худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хор хохирол учирсан бол хүнсний хяналтын байгууллага бие даан болон үйлдвэрлэгч, нийлүүлэгчидтэй хамтран хариуцлага хүлээж хохирлыг арилгана.

139 дүгээр зүйл.

Хэрэв гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага хууль зөрчин гэрчилгээ олгосон бол гэрчилгээ баталгаажуулалтын хураамжийг Магадлан итгэмжлэгдсэн захиргааны байгууллага хураан авч тус хураамжийн дүнг 5-10 дахин нэмэгдүүлэн торгох эсвэл 10,000 ₮ болон түүнээс доош бол 50,000 ₮ - 100,000 ₮ дүнгээр торгоно. Онцгой нөхцөлд үйл ажиллагааг зогсоох болон гэрчилгээг цуцлах буюу хүчингүй болгох ажиллагааг олон нийтэд зарлан хэрэгжүүлнэ. Удирдах албан тушаалтан болон шууд хариуцлага хүлээх гэрчилгээ олгогч нарын ажлын эрхийг цуцална.

Хуурамч байдлаар гэрчилгээ олгосон, мөн үүнээс үүдэн худалдан авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хор хохирол учирсан бол үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нар бие даан болон хамтран хариуцлага хүлээж хохирлыг арилгана.

140 дүгээр зүйл.

Худалдан авагчийг төөрөгдүүлэхээр худал сурталчилгаа явуулсан эсвэл зөвшөөрөл авалгүйгээр эрүүл мэндэд тустай хүнсний талаар сурталчилгаа хийсэн болон хуульд нийцээгүй үйл ажиллагаа эрхлэн явуулсан этгээдэд БНХАУ-ын Зар сурталчилгааны тухай хуульд үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

Хэрэглэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол учруулсан хууль зөрчин үйлдсэн хуурамчаар хүнсний сурталчилгааг зохиосон, чиглүүлсэн, хэвлэн нийтэлсэн этгээд бие даан болон үйлдвэрдэгчид нийлүүлэгч нартай хамтран хариуцлага хүлээнэ.

Хэрэглэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол учруулахуйц зохисгүй сурталчилгаа болон бусад хэлбэрээр хуурамч сурталчилгаа явуулж байгаа иргэдийн нийгэмлэг, бусад байгууллага, хувь хүн бие даан болон үйлдвэрдэгчид нийлүүлэгч нартай хамтран хариуцлага хүлээнэ.

Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний байгууллага, хүнсний хяналтын байгууллага, хүнсний үлйдвэрлэлийн холбоо зэрэг байгууллага хууль зөрчин хэрэглэгчдэд төлбөр хураамжийг өөрчлөн, илүү ашигтай байхаар сурталчлах ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хууль бусаар олсон орлогыг эрх бүхий байгууллага хураан авна. Менежер болон бусад шууд хариуцах ажиллагсдыг ажлаас түр завсарлуулах, албан тушаал бууруулах, ажлаас түр чөлөөлөх зэргээр шийтгэл оногдуулж болох ба онцгой тохиолдолд албадан ажлаас хална.

Ноцтой нөхцөл байдал үүссэн үед хуурамч хүнсний бүтээгдэхүүний сурталчилгаа хийсэн тохиолдолд харьяа мужийн болон түүнээс дээш шаны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг борлуулахын түр зогсоох арга хэмжээ авах ба шийдвэрээ нийтэд танилцуулна. Гэсэн ч тийм бүтээгдэхүүнүүд борлуулагдсаар байх тохиолдолд харьяа мужийн болон түүнээс дээш шатны Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хууль бус орлого болон хууль бусаар зарагдсан бүтээгдэхүүнүүдийг хураан авч 20,000-аас 50,000 ₮-аар торгоно.

141 дүгээр зүйл.

Энэхүү хуулийг зөрчин хүнсний аюулгүй байдалтай холбоотой худал мэдээллийг хуулбарласан болон түгээсэн этгээдэд захиргааны нийтийн аюулгүй байдлын дүрмэнд тусгагдсан эрх бүхий албан тушаалтнаас нийтийн аюулгүй байдлыг хамгаалахаар энэ хуульд нийцүүлж шийтгэл оногдуулна.

Ямар нэгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан худал хүнсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг хуулбарласан эсвэл түгээсэн бол харьяа эрх бүхий байгууллагаас удирдах албан тушаалтан болон холбоотой хүмүүст шийтгэл оногдуулна. Хэрэв иргэн, хуулийн байгууллага, бусад байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсэн бол учирсан хохирлыг арилгуулах, нэр төрөө сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй ба уучлал хүсэх өргөдлийг хүлээн авна.

142 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад доорх нөхцөл байдал учирсан тохиолдолд захирал буюу удирдах албан тушаалтан, холбогдох хүмүүсийг ажлаас түр завсарлуулах, албан тушаал бууруулах, онцгой тохиолдолд ажлаас халах зэргээр шийтгэл оногдуулна. Ноцтой үр дагавар гарсан тохиолдолд захирал буюу удирдах албан тушаалтан огцорно :

- i. Мужийн түвшний болон түүнээс дээш шатны орон нутгийн өөрөө удирдах байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах талаар үр дүнтэй ажиллахын тулд холбогдох ажлын хэсэг, тамгын газрын зохион байгуулж

чадаагүй, хэрэгтэй хууль тогтоомжийг цаг тухайд нь гаргаж чадаагүйгээс сөрөг нөлөөлөл болон хохирол учирсан,

- ii. Мужийн түвшний болон түүнээс дээш шатны орон нутгийн өөрөө удирдах байгууллага хууль зүйн эрхийнхээ хүрээнд бүсийн хүнсний аюулгүй байдлын асуудлыг засах болон зохион байгуулахдаа алдаа гаргаснаас сөрөг нөлөөлөл болон хохирол учирсан,
- iii. Мужийн түвшний болон түүнээс дээш шатны орон нутгийн өөрөө удирдах байгууллага хүнсний аюулгүй байдлын аливаа үйл явдлын талаар нуун дарагдуулсан, худал мэдээлсэн болон мэдэгдэхэд саад учруулсан,
- iv. Хүнсний аюулгүй байдалд онцгой нөлөөтэй эсвэл хэд хэдэн дараалалсан томоохон хэмжээний хүнсний аюулгүй байдлын асуудал харьяа бүс нутагт нь учирч байсан.

143 дугаар зүйл.

Мужийн түвшний болон түүнээс дээш шатны орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад доор дурьдсан нөхцөл байдал тулгарвал холбогдох удирдах албан тушаалтан болон ажил хариуцаж байсан хүмүүст сануулгын шийтгэл, ажлаас чөлөөлөх, онцгой чөлөөлөх арга хэмжээ, албан тушаал бууруулах, учирсан нөхцөл байдлыг засаж залруулах гэх шийтгэл оногдуулж болно :

- i. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллага хариуцаж авсан хүнсний аюулгүй байдал хяналт шалгалтын захиргааны байгууллагад хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүнсний хяналт болон удирдах механизм, мэдээлэл хуваалцах механизмын процессыг үүсгэж хөгжүүлэхдээ алдаа гаргасан, хүнсний аюулгүй байдлыг хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхдээ алдаа гаргасан бол,
- ii. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллага хууль зүйн эрхийнхээ хүрээнд хүнсний аюулгүй байдлын онцгой байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй болон хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсчихээд байхад эсвэл хэрэгжүүлээгүй тохиолдлууд хамаарна.

144 дүгээр зүйл.

Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага доорх нөхцөл байдалд орвол холбогдох удирдах албан тушаалтан болон ажил хариуцаж байсан хүмүүст сануулгын шийтгэл, ажлаас чөлөөлөх, онцгой чөлөөлөх арга хэмжээ, албан тушаал бууруулах, учирсан нөхцөл байдлыг засаж залруулах гэх шийтгэл оногдуулах ба онцгой тохиолдолд албадан ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч болно. Ноцтой үр дагавар гарсан тохиолдолд захирал буюу удирдах албан тушаалтан албан тушаалаасаа огцорно :

- i. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага хүнсний аюулгүй байдалд учирсан аюулыг нуун дарагдуулсан, худал мэдээлсэн болон мэдээлэхэд саад учруулсан,
- ii. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага, хүнсний аюулгүй байдалд учирсан аюулыг судалж тогтоож чадаагүй эсвэл мэдэгдсэн хүнсний аюулгүй байдлын асуудлыг даван туулж чадаагүй болон уг байдал цааш тархахад хүргэсэн бол,
- iii. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллагаас аюултай хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хүнстэй холбоотой бүтээгдэхүүний эрсдлийн үнэлгээг хийлгэсний дараа холбогдох арга хэмжээг аваагүй,
- iv. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллагаас шалгуур хангаагүй этгээдэд лиценз олгосон, эсвэл ажил үүргийн хуваариас давуу нөхцлөөр лиценз олгосон тохиолдолд,
- v. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага хяналт шалгалт хийх хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс хүнсний аюулгүй байдалд асуудал үүсгэсэн нөхцөл байдлууд хамаарна.

145 дугаар зүйл.

Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага доорх нөхцөл байдлыг үүсгэвэл холбогдох удирдах албан тушаалтан болон ажил хариуцаж байсан хүмүүст сануулгынн шийтгэл, ажлаас чөлөөлөх, онцгой чөлөөлөх арга хэмжээ, албан тушаал бууруулах, учирсан нөхцөл байдлыг засаж залруулах гэх зэрэг шийтгэл

оногдуулах ба онцгой тохиолдолд албадан ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч болно:

- i. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага дээд эрх мэдлийн байгууллагууддаа болон адил түвшний байгууллагууддаа тайлагнаагүй болон хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг олж авсаныхаа дараа уг мэдээллийг хүргүүлээгүй,
- ii. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг нийтэд мэдэгдээгүй орхисон,
- iii. Харьяа орон нутгийн болон дээд шатны өөрөө удирдах байгууллагын хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн удирдлагын захиргааны байгууллага нь хүлээсэн хууль ёсны үүргээ гүйцэтгээгүй, хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль бус үйл ажиллагааг эсэргүүцээгүй, эрх мэдлээ урвуулан ашигласан, эсвэл хувийн ашиг сонирхлынхоо төлөө хууль зөрчин буруутай үйлдэл хийсэн тохиолдлууд хамаарна.

146 дугаар зүйл.

Хүсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага, чанарын хяналт шалгалтын захиргааны байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хуулийн дагуу сахиулах үүргээ гүйцэтгэх явцдаа хууль бус үйлдэл үйлдэж холбогдох үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдэд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлж тухайн байгууллагын удирдах албан тушаалтан болон холбогдох хамааралтай этгээдүүд энэхүү хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

147 дугаар зүйл.

Энэ хуулийг зарчсөн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний хувийн эрх ашиг, эд хөрөнгө болон бусад төрлийн хохирол учирсан бол нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй. Тухайн үйлдвэрлэгч болон нийлүүлэгч этгээдийн хөрөнгө нь иргэний нөхөн олговрыг төлөх ба торгууль буюу шийтгэлийн мөнгийг төлөхөд хүрэлцэхээргүй байвал эхний ээлжид иргэний хохирлыг төлж барагдуулна.

148 дугаар зүйл.

Хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнсний бүтээгдэхүүнээс болоод хэрэглэгчид ямар нэгэн хохирол учирсан бол үйлдвэрлэгч юмуу нийлүүлэгчээс хохирлоо төлүүлэхийг шаардах эрхтэй ба үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нь уг хохирлыг нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэлийг хүлээн авч хамгийн түрүүнд иргэний хохирлын арилгах үүрэгтэй ба нөхөн төлбөр төлөхөөс татгалзаж болохгүй. Хэрэв энэ асуудал нь нь үйлдвэрлэгчтэй холбоотой бол нийлүүлэгчийн зүгээс уг нөхөн төлбөрийг үйлдвэрлэгчээс нөхөн төлүүлэх боломжтой. Хэрэв энэ асуудал нь нийлүүлэгчтэй холбоотой бол үйлдвэрлэгч уг нөхөн төлбөрийг нийлүүлэгчээс авах боломжтой.

Үйлдвэрлэгч нь хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй гэдгийг мэдсээр байж хүнсний аюулгүй байдлын стандартад нийцээгүй хүнс үйлдвэрлэсэн эсвэл нийлүүлсэн тохиолдолд хэрэглэгч нь өөрт учирсан хохирлыг тухайн үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчээр нөхөн төлүүлэхээс гадна өөрийн төлсөн дүнг 10 дахин нэмэгдүүлсэн эсвэл хохирлын хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэн дүнгээр нэхэмжлэх боломжтой. Хүнсний шошго болон заавар дээрх мэдээлэл хүнсний аюулгүй байдалд нөлөөгүй эсвэл хэрэглэгчдийг төөрөгдүүлээгүй тохиолдод тухайн нэмэлт нөхөн төлбөрийн хэмжээ 10,000 ₮ - аас бага байвал нэмэлт нөхөн төлбөрийг 10,000 ₮ хүртэл нэмэгдүүлж төлнө.

149 дүгээр зүйл.

Энэ хуулийг зөрчин эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн ял хүлээлгэнэ.

Аравдугаар бүлэг

Нэмэлт заалт

150 дугаар зүйл.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд дараах нэр томъёонуудыг дор дурьдсан утгаар ойлгоно :

Хүнс гэдэгт идэх мөн/эсвэл уух зориулалттай, боловсруулсан болон боловсруулаагүй бодисыг ойлгох ба үүнд Хятадын уламжлалт эмийн гаралтай бүтээгдэхүүн хамаарах боловч дангаар нь эмийн зориулалаар хэрэглэж болох эм бэлдмэл хамаарахгүй болно.

Хүнсний аюулгүй байдал гэдэгт хортой бодис агуулаагүй, хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, шаардлагатай тэжээллэг чанарын үзүүлэлтийг хангасан, ямар нэгэн цочмог болон архаг эмгэг үүсгэхгүй ба хүний эрүүл мэндэд аюул учруулахгүй гэсэн баталгааг ойлгоно

Урьдчилан савлагдсан хүнс гэдэгт урьдчилан савлагдсан эсвэл хүнс хадгалах агуулах, савлах материалд хийгдсэн тодорхой хэмжээтэй зүйлийг ойлгоно.

Хүнсний нэмэлт гэдэгт хүнсний бүтээгдэхүүнд нэмэлтээр чанар, өнгө, үнэр, амт оруулах, хадгалах хугацааг уртасгах болон технологийн ажиллагааны шаардлагаар зориудаар нэмдэг синтетик болон байгалийн бодис, хольцыг ойлгоно.

Хүнсний агуулах болон савлах материал гэдэгт цаас, хулс, мод, металл, шаазан, хуванцар, резин, байгалийн гаралтай болон химийн материал болон шил зэргээр хийгдсэн хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай, эсвэл тэдгээрт шууд нөлөөлөх боломжтой бүрхэвчийг ойлгоно.

Хоол хүнсний багаж хэрэгсэл гэдэгт машин, хоолой, конвейер, агуулах сав, цахилгаан хэрэгсэл, хоолны хэрэгсэл болон хүнс болон нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, нийлүүлэхэд шууд нөлөө үзүүлэх зүйлсийг ойлгоно.

Хүнсний угаалгын нунтаг, ариутгагч бодис гэдэг нь хүнсний бүтээгдэхүүнд шууд нөлөө үзүүлэх боломжтой хүнс хадгалах сав, хоолны хэрэгсэл, хүнсний багаж хэрэгсэл, агуулах болон савлах материалыг угаах болон ариутгах зориулалттай бодисыг хэлнэ.

Хүнсний хадгалалтын хугацаа гэдэг нь зориулалтынх нь дагуу хадгалахад чанараа алдаагүй, шошгон дээр ашиглаж болох сүүлийн хугацааг тэмдэглэсэн ба тухайн хугацаанаас өмнө ашиглах ёстой хугацаа хамаарна.

Хүнсний гаралтай өвчин гэдэгт хүнсний бүтээгдэхүүнээс гадна хоолоор дамжин хүний эрүүл мэндэд халдварлах, хордуулах, өвчин үүсгэх эмгэг төрүүлэгч бичиг биетэн агуулсан зүйлийг ойлоно.

Хүнсний аюулгүй байдлын асуудал гэдэгт хүнсний гаралтай халдварт өвчин үүсгэх, хүнсний бүтээгдэхүүний бохирдол үүсгэх болон хүний эрүүл мэндийг хордуулах ямар нэгэн тохиолдлыг ойлгоно.

151 дүгээр зүйл.

Энэ хуульд заагаагүй генийн өөрчлөлттэй хүнс болон хоолны давсны талаар Хүнсний аюулгүй байдлын хяналтын байгууллага өөр хууль болон захиргааны зохицуулалтаар хариуцлага хүлээлгэнэ.

152 дугаар зүйл.

Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага нь Төрийн зөвлөлийн харьяа бусад байгууллагуудтай хамтран төмөр замаар болон агаарын замаар тээвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавин ажиллана.

Эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүний талаарх захиргааны арга хэмжээг Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

Хүнстэй холбоотой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх захиргааны тодорхой арга хэмжээг Төрийн зөвлөлийн харьяа Хүнсний болон эмийн гаралтай бүтээгдэхүүний хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

Хилийн боомтоор хүнсний бүтээгдэхүүн оруулах хяналтын болон удирдлагын арга хэмжээг Зах зээлийн оролт-гаралтын шалгалт ба хорио цээр тогтоох байгууллагаас энэ хууль болон холбогдох бусад хууль, захирамжилсан арга хэмжээнд үндэслэн хэрэгжүүлнэ.

Зэвсэгт хүчинд хэрэглэгдэх онцгой хүнсний бүтээгдэхүүн болон тэжээллэг бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдал болон хоол хүнс хэрэглэх талаар энэ хуульд нийцүүлэн Төв цэргийн хороо уг асуудлыг хариуцна.

153 дугаар зүйл.

Төрийн зөвлөлөөс тухайн цаг үеийн шаардлагаас үүдэн хүнсний аюулгүй байдал болон хяналтын ба захирамжлах арга хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

154 дүгээр зүйл.

Энэ хуулийг 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.